



# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.10.20, БААСАН ~ №201 (747)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 600Т

## Сайд нарын томилгоог цаг сунган хэлэлцэв

Х.Баделхан: Найман хувийн ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. > 2

## Тэжээвэр амьтдыг тойрсон мөнгөний эргэлт

Улаанбаатар хотын хэмжээнд 60 орчим мянган тэжээвэр нохой байдаг. > 5



■ Цахиурын хөндий болох Японы өрсөлдөөн  
■ YouTube-ийн хиймэл оюун экстремист видео бичлэгийг ялгаж байна

## Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонин цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын зургадугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- lkon.mn
- Xoroom.com
- Caak.mn
- Zалуu.com
- Ubinfo.mn
- Medee.mn
- News.mn
- Biznetwork.mn
- View.mn

Эх сурвалж: Alexa.com ©

## ОНЦЛОХ

### УЛС ТӨР

**Ерөнхийлөгчийн санаачилгаар** Агаарын бохирдлыг бууруулах үндэсний чуулган болно. **АНУ-д болсон зэвсэгт халдлагад** өртсөн МУ-ын иргэний ар гэртэй ГХЯ холбогджээ. **М.Энхболд Энэтхэгийн** Төрийн албаны төв комиссын даргатай уулзлаа. **НИТХ өчигдөр хуралдах ёстой** байсан ч мөн л ирц хүрээгүйн улмаас хойшлов. **МУ уул уурхайтай орнуудын** ЗГ хоорондын байгууллагын гүйцэтгэх хорооны гишүүн болов.

### ЭДИЙН ЗАСАГ


**Далд уурхайн IV босоо амны** ажлыг 2018 оноос эхлүүлнэ. **Ноолуурын компаниудын** орлого дунджаар 28 хувиар өсчээ. **БНХАУ-ын эдийн засаг** өнгөрсөн улиралд жилийн дүнгээр 6.8 хувиар өслөө. **Австралийн ажилгүйдлийн** түвшин наймдугаар сард 5.5 хувьд хүрчээ. **БНСУ-ын төв банк мөнгөний** бодлогын жишиг хүүгээ 1.25 хувьд хэвээр үлдээв.

### НИЙГЭМ

**БНСУ-д хөдөлмөр эрхлэх** иргэдийн сонгон шалгаруулалтад өөрчлөлт орлоо. **Сэлэнгэ аймгийн Түшиг суманд** таван магнитудын хүчтэй газар хөдөлжээ. **Зүрхний гажигтай 41 хүүхэд** эмчлүүлэхээр Бээжин хотыг зорилоо. **БЗД-ийн ИТХ-ын шийдвэрүүд** хуурамч тамгаар баталгаажив байна гэв. **Агаар орчны бохирдлыг** бууруулах техник, технологийн мэдээллийн төвтэй болно. **ДЭЛХИЙ** **БНХАУ сүүлийн таван жилд нам,** төрийн 2.6 сая ажилтанд авлигын хэрэг үүсгэжээ. **АНУ-ын Конгрессын 40 гаруй** гишүүн Мьянмарт хориг тавих саналтай байна. **Японд аялагч гадаадынхны** тоо энэ онд түүхэн үнэмлэхүй буюу 21 саяд хүрлээ. **Нидерланд ариун цэврийн** ашигласан цаасаар зам барихаар төлөвлөж байна. **Германд далавчит шавжны** 75 хувь устаад байгааг эрдэмтэд сэрэмжлүүлэв.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР  
2017.10.20



7° | -4°

ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИЙГ МЭДЭЭЛЛИЙГ  
8 ДУГААР НУУРГУУС УНШИНА УУ



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

# Мацаж буй махны экспорт



Махны экспортын нийт орлогын 80 хувийг зөвхөн адууны мах бүрдүүлжээ. Энэ онд адууны махны экспорт ойролцоогоор хоёр дахин өсөж, 20 сая ам.доллар давсан байна. ▶11

Б.Ганбаяр / ЗГМ ©

## НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

### Цагаан хорыг “номхотгох” ерөндөг

Б.Баярмаа  
@bayarmaazGM

Амттан өрсөн лангууны хажууд хошуугаа цорвойлгох хүүхдээ өрөвдөж, өхөөрдсөндөө найр тавих тохиолдол бишгүй л гардаг. Бид хүүхдэдээ чихэр хортой гэж өдөр бүр үглэх хэрнээ өөрсдөө авч өгөөд байдаг сонин хэвшилтэй улс. Хүүхдээ баярлуулна гээд уут дүүрэн чихрээр “хордуулах” тун дуртай. Монголчууд глюкоз буюу сахарыг гурван цагаан хорын нэг гэдэг нь учиртай. Сахар их хэрэглэх нь XXI зууны тахал гэх гуншинтай таргалалтын нэг эх үүсвэр болдог. Чихэр ихтэй

амттан, ундаанд хүний биед хэрэгтэй шим тэжээл тун бага хэрнээ илчлэгийн хэмжээ үлэмж. Сахарын хор уршиг болон ашигт чанарыг харьцуулбал тэмээ, ямаа гэсэн үг.

### ИЛҮҮДЭЛ ЖИНГИЙН “ДАРЛАЛ”

Дөчин жилийн өмнө дэлхий дээр 100 сая хүн илүүдэл жинтэй байсан бол 2016 оны байдлаар энэ тоо бараг долоо дахин нэмэгдэж 671 саяд хүрсэн байна. Ялангуяа, хүүхдүүдийн таргалалт 10 дахин нэмэгдсэн нь улс орнуудад аюулын харанга дэлдсэн гэсэн үг.

▶3

## ЗГМ: ЗОЧИН

### Д.Загдсүрэн: Бид өөрсдийн чадал, боломжинд таарсан наадмуудыг зохион байгуулах ёстой

Б.Баярсайхан  
@bayarsaikhanZGM

Монголын үндэсний олимпын хороо (МҮОХ)-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэнг “ЗГМ: Зочин” буланд ая хурьж, ярилцлаа. Бидний ярилцлага орчин үеийн олимпын чиг хандлага, олон улс дахь Монголын спортын нэр хүнд, Токиогийн олимпын бэлтгэл

болон спортоор дамжуулан улс орноо хөгжүүлэх боломж гээд олон сэдвийн хүрээнд өрнөсөн юм.

-Хэд хоногийн өмнө олимп, дэлхийн аварга, домогт тамирчин С.Бубка МҮОХ-нд зочилж, хамтран ажиллах гэрээ байгууллаа. Спортын салбарынхны ярьснаар спорт өндөр хөгжсөн Украины улстай нэлээд өргөн хүрээнд хамтран

ажиллахаар тохиролцсон гэсэн. Хамтын ажиллагааны талаар тодруулж өгнө үү?

-С.Бубка бол дэлхийн рекордыг олон удаа шинэчлэн тогтоосон дэлхийн хэмжээний домогт тамирчин. Нөгөө талаасаа олон улсын түвшинд олимпын хөдөлгөөнийг дэмжигч нэрт зүтгэлтэн хүн.

▶6

## МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад Гаалийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 105 жилийн ойг тохиолдуулан гаалийн салбарт ажиллаж байсан үе үеийн ахмадууд, тэдний үйл хэргийг залгамжлан үргэлжлүүлж буй гаалийн нийт албан хаагчид, тэдний гэр бүл, гаалийн харилцаанд оролцогч Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Түүхийн хуудаснаас сөхвөл, Төр улс үүссэн тэртээх цаг үеэс Гаалийн алба нь туурга тусгаар улсын оршин тогтнох, эдийн засгийн бие даасан байдалд хувь нэмэр оруулсаар ирсэн болох нь дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхээс харагддаг. Шинэ үеийн хэмээх тодотголтой гаалийн алба Олноо өргөгдсөн Богд хаан 1912 оны зуны тэргүүн сарын шинийн хоёрны билэгт сайн өдөр зарлиг буулган “Гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам”-ыг Сангийн яамны баруун этгээдэд гэр барьж байгуулснаар өнөөгийн

гаалийн албаны суурь тавигдсан түүхтэй. Дэлхийн 182 орныг эгнээндээ нэгтгэсэн Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн, Монгол Улсын Гаалийн байгууллага өнөөдөр зуун дамна хийсэн ажлын амжилт бүтээлээ төр засгаараа үнэлүүлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор шагнуулж байгаадаа бахархаж байна.

Гадаад худалдааны өсөн нэмэгдэх урсгалд өөрийн үндсэн чиг үүрэг болсон нэг талаас хууль сахиулах, нөгөө талаас худалдааг хөнгөвчлөх гэсэн эрс тэрс чиг үүргийг тэнцвэртэйгээр хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа шинэчлэлт, өөрчлөлт хийж, шинийг эрэлхийлсээр ирсэн. Бид 2017 оны эхний 9 сарын байдлаар улсын төсөвт 1.4 их наяд төгрөгийн гаалийн орлогыг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг 111 хувиар давуулан биелүүлсэн сайхан



амжилтаар түүхт ойн баяраа угтлаа. Монголын Улсын гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагаас батлан гаргасан бодлогын баримт бичгүүдтэй үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж, олон улсын чиг хандлагад нийцсэн төрийн үйлчилгээг гаалийн харилцаанд оролцогчлоод үзүүлэн Монгол Улсын Гаалийн нэрийг дэлхийн тавцанд хүргэж, бус нутгийн хэмжээнд тэргүүлэх гааль болохыг зорьж байна.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭНД ХАМТДАА ЗҮТГЭЦГЭЭ. ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ГААЛИЙН ЖИНХЭНЭ ЗӨВЛӨХ БАСРАЛТ

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1167.92 0.18%	1282.80 0.18%	6990 0.53%	98.480 0.12%	100.66 0.03%	2460.58	373.55	42.73

## Улс төр

## ЗАСГИЙН ГАЗАР

## Сайдуудын томилгоог цаг сунган хэлэлцлээ

Орон сууцны найман хувийн хүүтэй зээлийг үргэлжлүүлнэ гэдгээ мэдэгдэв

Б.Даваатогтох  
@datoZGM

УИХ хоёр дахь өдрөө хугацаа сунган хуралдаж, шинэ Засгийн газарт ажиллах сайдуудын томилгоог хэлэлцлээ. Эхний өдөр Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга болон ерөнхий чиг үүргийн яамдыг удирдах найман сайдыг томилсон бол өчигдөр Барилга, хот байгуулалтын сайдаар Х.Баделханыг томилсноор хуралдаанаа эхлүүлэв. Үргэлжлүүлэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Ж.Цогзолмааг, Зам, тээврийн хөгжлийн сайдаар Ж.Бат-Эрдэнийг томиллоо.

Энэ үеэр УИХ-ын гишүүд томилогдож буй сайд нараас салбартаа ямар бодлого баримтлахыг тодруулахын зэрэгцээ юунд анхаарах ёстойг хэлэв. Тухайлбал, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан орон сууцны найман хувийн хүүтэй зээлийг үргэлжлүүлнэ гэдгээ мэдэгдэв. Гэхдээ санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг онцлоо. Ипотекийн зээлийг олгож эхэлснээр нийт 4.1 их наяд төгрөгийн зээлээр 92 мянган иргэн орон сууцтай болсон байна. Зээлийн эргэн төлөлт 95 хувьтай байгаа бөгөөд энэ онд 10 мянга орчим өрх орон сууцтай болсныг тэрбээр дуулгав. Үүнээс гадна гацаанд ороод буй гэр хорооллын дахин төлөвлөлтийг бодит ажил хэрэг болгох, барилгын салбарын лиценз, тусгай зөвшөөрлийг цэгцэлж хүнд суртлыг арилгах, болон хотын шинэ цэвэрлэх



Б.Ганбаяр / ЗГМӨ

байгууламж барих асуудлыг шийдвэрлэхэд онцгойлон анхаарч ажиллана гэв. Онцлоход, концессын асуудалд анхаарч, шаардлагатай гэж үзвэл барих-ашиглах-шилжүүлэхийг зөвшөөрч болох юм гэсэн байр суурьтай байгаагаа Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан илэрхийллээ.

Харин Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Цогзолмаа салбарынхаа ойрын, дунд, урт хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгийг боловсруулах шаардлага тулгарч буйг онцлов. Энэ хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсронгуй болгох, сурах бичгийг журамлах ажлыг цаг алдалгүй эхлүүлэх аж. Үүнээс гадна маргаан дагуулаад буй багш нарын

цалин нэмэх асуудалд, “Багш нарт олгох урамшууллыг нэмэгдүүлэх замаар цалинг нь өсгөх боломжтой. Энэ чиглэлээр тооцоо судалгаа хийсний үндсэн дээр асуудлыг шийдвэрлэхэд анхаарна” гэлээ.

### Уул уурхай, эрдэс баялгийн салбарт нэг цонхны бодлого явуулна

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг нэн тэргүүнд дуусгах ёстойг тодотгов. Харин авто замын тухайд “Авто замын сүлжээний нэн тэргүүний зорил-

го нь аймгийн төвүүдэд холбох. Хоёрдугаарт, эдийн засагт хэрэгтэй тэргүүлэх чиглэл болох уул уурхай, аялал жуулчлалын дэд бүтцийн сайжруулна” гэлээ. Нүүрсний экспортыг сааруулж буй Гашуунсухайт-Ганцмодны боомт сүүлийн гурван сарын турш хагас нээлттэйгээр үйл ажиллагаагаа явуулж буй. Энэхүү нөхцөл байдал үүсэхээс өмнө уг боомтоор өдөрт 1500-1600 автомашин нэвтрүүлж байв. Харин аравдугаар сарын 11 гэхэд уг боомтоор 500 орчим машин нэвтрүүлсэн юм. Тэгвэл хүндрэлтэй байгаа энэхүү нөхцөл байдлыг яаралтай шийднэ гэдгээ Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ “амласан” юм. Тэрбээр холбогдох сайдуудын хамтарсан туслаалаар Ажлын хэсэг байгуулж, газар дээр нь ажиллаж, шийдэхээр төлөвлөж

буй аж.

Дугаар шилжих мөчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар Д.Сумъяабазарыг томилсон юм. Тэрбээр уул уурхай, эрдэс баялгийн салбарт нэг цонхны бодлого явуулахаа илэрхийллээ. Тэрбээр “Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай. Гэхдээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах нь чухал. Нүүрсийг угааж, баяжуулж гаргахад анхаарал хандуулна. Үүнд тээвэрлэлтийн асуудал хөндөгдөнө. Зам, тээврийн хөгжлийн сайдтайгаа хамтраад төмөр замыг асуудлыг яаралтай шийдвэрлэнэ” гэв.

Хоёр дахь өдрөө үргэлжилсэн сайдуудын томилгоог дуусгах товтой байгаагаа өчигдөр УИХ-ын дарга М.Энхболд илэрхийлсэн юм. [ЗГМ]

## СУДЛААЧ ЯРЬЖ БАЙНА

## Д.Золбоо: Хятад улс ирэх жилүүдэд бодлогын эрс өөрчлөлт хийхгүй

Ши Жиньпин амлалтаа хангалттай биелүүлсэн хэмээн дүгнэж байна

Б.Тогтох  
ЗГМ

БНХАУ-ын Коммунист намын XIX Их хурал өнгөрсөн даваа гарагт Бээжин хотноо эхэлсэн. Энэ талаар судлаач, доктор Д.Золбоотой ярилцлаа.

-БНХАУ-ын дарга Ши Жиньпин хурлын нээлттэй тавьсан. Энэхүү илтгэлийг олон улсын шинжээчид янз бүрээр тайлбарлаж байна. Судлаач хүний хувьд үүнд ямар дүгнэлт хийсэн бэ?

-Таван жилд нэг удаа болдог учир олон улсын анхаарлын төвд байна. Шинжээчид өнгөрсөн таван жилийн хугацаанд тус улсын удирдагч Ши Жиньпин амлалтаа хангалттай биелүүлсэн хэмээн дүгнэж байна. Учир нь XIX Их хурлын нээлтийн үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин гурван цагийн турш улс төрийн илтгэл тавьж, амлалтаа хэрхэн биелүүлснээ тайлагнасан. Мөн ирэх жилүүдэд Хятад улсыг

хэрхэн удирдах, хөгжлийн ямар бодлого баримтлахаа ч тодорхойлсон. БНХАУ-ын 100 жилийн ойгоор тус улс дэлхийн эдийн засгийн гол тоглогчдын нэг болохын зэрэгцээ хүчирхэг дундаж давхаргыг бий болгох зорилт тавилаа. Үүнээс гадна дотооддоо чиглэсэн бодлогод түлхүү анхаарал хандуулахаа илэрхийллээ. Ингэхдээ өнгөрсөн таван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ажил буюу авлига хээл хахуулийн эсрэг хүчтэй тэмцэл өрнүүлж, бүс нутаг болон дэлхийн эдийн засагт голлох байр суурийг эзлэх бодлогоо үргэлжлүүлнэ. Үүнээс гадна дэлхийн ангиллын цэргийн армитай болохоо мэдэгдлээ. Өнөөдрийн байдлаар батлан хамгаалахын салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээр АНУ дэлхийд тэргүүлж байгаа.

-Урд хөршийн төрийн эрхийг барьж буй улс төрийн хүчний энэхүү хурал олон улсын санхүүгийн зах зээлд ихээхэн нөлөө үзүүлнэ. Тиймээс олон улсын ажиглагчид анхааралтай ажиглаж, дүгнэлт хийж байна. Хятадын нөлөөлөл бүс нутагт болон дэлхийд хүрээгээ тэлж буй. Одоо баримталж буй бодлогод эрс өөрчлөлт гарах уу?

-Хятад улс сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад хөнгөлөлттэй зээл, тусламжийг их хэмжээгээр үзүүлэх болсон.



Б.Ганбаяр / ЗГМӨ

Энэхүү зээл, тусламжийн хэмжээгээрээ АНУ-ын дараа орж байгаа гэсэн статистик тоо бий. Хэрэв энэхүү статистик тоо үнэн бол өмнөд хөршийн нөлөөлөл бүс нутагт хийгээд бодлогын эрс өөрчлөлт хийхгүй гэсэн таамгийг дэвшүүлж буй.

-Гэхдээ энэ удаагийн хурлаар тус улсын удирдлагын багт өөрчлөлт хийх асуудал яригдаж буй. Хэрэв удирдлагын багт өөрчлөлт орвол дагаад баримтлах бодлогод өөрчлөлт орохгүй юу?

-Удирдлагын багт долоон хүн бий. Үүнээс таван гишүүн нь солигдох магадлалтай. Гэхдээ энэхүү долоон гишүүний орон тоог цөөлөх тухай яриа гарах болсон. Анх Мао Зэдуны үед удирдлагын баг таван гишүүнтэй байсан. Сүүлд буюу 2012 онд болсон XVIII Их хурлаар ес байсныг долоо болгон бууруулсан. Тиймээс энэ удаагийн хурлаар гишүүдийн тоог цөөлөх магадлал бий. Хэрэв өөрчлөлт оруулбал гурван гишүүнийг л солих шаардлагатай болно. Удирдлагын багт өөрчлөлт орсон ч эрс шинэчлэл хийх боломжгүй хэмээн олон улсын шинжээчид таамаглаж буй. БНХАУ-ын дарга Ши Жиньпин нээлтийн үгэндээ бусдын санал болгож буй хувилбарыг сонгох

шаардлагагүй гэдгийг онцолсон. Өөрөөр хэлбэл, өөрсдийн онцлогтой социализмыг байгуулна гэдгээ илэрхийлсэн юм.

-Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр болон цөмийн пуужингийн удаа дараагийн туршилтаас үүдэн Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдаж буй. Бүс нутгийн аюулгүй байдалд Хятад улсын байр суурь хүчтэй байгаа. Цаашид энэ асуудалд Хятад улс ямар бодлого баримтлах бол?

-Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг хангахад Хятадын оролцоо ихээхэн чухал. Хойд Солонгостой хиллэж байгаа учир Солонгосын хойгийн асуудлыг тайван замаар шийдвэрлэх байх гэсэн таамаг бий. [ЗГМ]

## ТОВЧХОН

## » ХУРАЛ

ГХЯ-ны Олон улсын хамтын ажиллагааны сан “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудал: Монгол Улсын жишээ” сэдэвт олон улсын хурлыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хууль боловсруулах үйл явцыг сайжруулах асуудлаар гадаад, дотоодын төрийн албан хаагчид, эрдэмтэн, судлаачдын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, туршлага хуваалцах, судлах зорилготой юм.

## » УУЛЗАЛТ

УИХ-ын дарга М.Энхболд Энэтхэг улсын Төрийн албаны төв комиссын дарга Давид Р.Суемлехийг хүлээн авч уулзлаа. Төрийн албаны төв комиссын дарга Давид Р.Суемлех монгол оюутнуудыг бакалаврын болон магистрын түвшний сургалтад, төрийн албан хаагчдыг давтан сургах чиглэлээр манай Засгийн газраас хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Үүнийг цаашид үргэлжлүүлж, хамрагдах хүрээг өргөжүүлэхэд анхаарал хандуулна хэмээсэн юм.

## » ТОО

1.2

Тэрбум ам.доллар. Өнгөрсөн 26 жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад нийт хоёр тэрбум орчим ам.долларын зээл, тусламжийг үзүүлсэн байдаг. ОУВС-гаас хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд тус банк ирэх дөрвөн жилийн хугацаанд 1.2 тэрбум ам.долларын санхүүгийн дэмжлэгийг Монгол Улсад үзүүлэхээр болсон.

## ЭШЛЭЛ



-Намууд дотор үзэл бодол, санал нийлдэг хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл байдаг юм. Гагцхүү ямар эрх ашгийг нэгдүгээрт тавьж байна вэ гэдэг нь чухал. Манай АН-ын шинэчлэл явагдаад нийт гишүүдээсээ асуудаг болсон процесс нь үзэл бодлын тодорхой зөрүү байсан ч бид эцсийн үр дүнгээ хүлээн зөвшөөрдөг болсон. Яг үнэндээ АН дотор фракцууд саармагжсан уу гэвэл саармагжсан. Яагаад саармагжсан бэ гэвэл нэгэнт бид Ардчиллын шинэчлэлийн бодлогынхоо хүрээнд өөрсдийнхөө дүрэмд захирагдаж явах ёстой гэдгийг ойлгож байгаа. Энэ зөв эхлэлээ цааш нь яаж институт болгох уу гэдэг дээр санаа зовж байна. Дан ганц манай нам үүнийг хийхгүй юм. Ер нь улс төрийн бүх нам ийм байх ёстой гэсэн хандлага сүүлийн үед ажиглагдаж байна. Тийм учраас Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг өөрчлөх хэрэгтэй байна. Төрийн бодлого улс төрийн намаар дамжиж байгаагийн хувьд улс төрийн намуудаа харууцлагатай болгож, гишүүд дээ тодорхой шалгуур тавих цаг ирсэн байна.

УИХ дахь АН-ын бүлгийн дарга  
Д.Эрдэнэбат

## ТОДРУУЛГА &amp; ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» [INFO@ZASAG.CO](mailto:INFO@ZASAG.CO)

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

## Нийтлэлчийн булан

**Сахарын хэрэглээг татвараар бууруулах боломжтой**

◀

Хүүхдүүд илүүдэл жинтэй байна гэдэг ирээдүйд эрүүл мэндийн салбарт, цаашлаад эдийн засагт ч асар их бэрхшээл дагуулдаг тул яаралтай арга хэмжээ авахыг олон нийтийн байгууллагууд ч шаардаж эхэлсэн. Илүүдэл жинтэй байх нь чихрийн шижин, зүрхний шигдээс зэрэг амь насанд аюултай, архаг өвчин тусах магадлал өндөр. Харин өдөрт 1-2 сав чихэртэй ундаа хэрэглэдэг хүн эдгээр өвчинд нэрвэгдэх эрсдэл даруй 26 хувиар нэмэгддэг аж.

АНУ-ын Туфтсын их сургуулийн эрдэмтэд дэлхийд 100 нас баралт тутмын нэг нь сахараас үүдсэн таргалалт, түүнээс улбаалсан өвчнөөс шалтгаалдаг гэж үзжээ. Жилд 184 мянган хүн сахарын хэт их хэрэглээнээс амиа алддаг байна. Харин үүний 76 хувийг дунд болон бага орлоготой орнуудад тохиолддог гэсэн судалгаа гаргажээ. Энэ жагсаалтыг Мексик улс жилд 24 мянга гэсэн тоогоор тэргүүлдэг аж.

Сахарын хэт их хэрэглээ нь таргалалтын гол шалтгаан гэдгийг илтгэх нотолгоо тун олон. Тухайлбал, өөрсөд дээрээ жишээ авъя. Монголчуудын хувьд сүүлийн жилүүдэд мөн л дээр дурдсантай адил дүр зураг харагдаж буй. Монголчуудын 54.4 хувь нь илүүдэл жинтэй, 19.7 нь хэт тарган гэсэн судалгаа бий.

Өөрөөр хэлбэл, хүн амын тал нь илүүдэл жинтэй бол ойролцоогоор тавны нэг нь хэт тарган гэсэн ангилалд багтаж байгаа нь харамсалтай. Энэ дунд амтанд дуртай эмэгтэйчүүд жин дарж, 69.3 хувийг эзэлж байна. Харин 2016 оны Хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаанаас харахад 15-44 насны эмэгтэйчүүдийн чихэр амттан, ундааны хэрэглээ бусдынхаас 2-3 дахин их гэсэн дүн гарчээ. Уг судалгаанаас монголчууд өдөрт 11 гр амттан, чихэртэй ундаа хэрэглэдэг гэсэн тооцоог харж болно. Харин яг өдөрт хэдэн гр сахар хэрэглэдэг талаар нарийн тооцсон судалгаа манай улсад алга. Гэхдээ өөрийнхөө сахарын хэрэглээг өдөрт иддэг амттанаар тооцож болох юм.

Өдөрт 26 гр сахар хэрэглэхийг дундаж үзүүлэлт гэж олон улсад тооцдог. Бидний өргөн хэрэглэдэг зарим амттанг хэмжиж үзвэл 750 гр жүүсэнд 82 гр, 100 гр зөөлөн чихэрт 91, 270 грамм жигнэмэгт 112 гр сахар агуулагдаж байна. Өдөрт эдгээр амтганаас нэгийг л иддэг бол сахарын хэрэглээ ихтэйд тооцогдоно. Ингэж үзвэл, бидний ихэнх нь, ялангуяа хүүхдүүдийн сахарын хэрэглээ тун өндөргарч байна. Зөвхөн чихэр, жимс идсээр байгаад тууралд орж, эмнэлэгт хэвтсэн хүүхдийн тухай ч сонсож байлаа.



Иргэд өөрсдөө хэрэглээг хянаж чадахгүй байгаа тул ийм үйлдвэрлэл эрхлэгчдэд төр төмөр нүүрээ харуулахад болохгүй зүйлгүй.

BVM©

# Цагаан хорыг “НОМХОТГОХ” ерөндөг

**ДАВХАР АШИГТАЙ ТАТВАР**

Тэгвэл эрүүл мэндэд ноцтой аюул учруулж, үхэл тарьдаг цагаан хорыг хэрхэн багасгах вэ. Хортэй гэдгийг нь мэдсээр байж идсээр байдаг амттай хорыг хэрхэх вэ. Үүний хариулыг Данийн улстөрчид 90 орчим жилийн өмнө олж, өдгөө дэлхийн хамгийн сайн эрүүл мэндийн системтэй орноор тодродог байна. Тус улс 1930 онд чихэртэй ундаанд анх удаа онцгой татвар ногдуулжээ. Учир нь жүүс, гаазтай болон чихэртэй ундаа хамгийн их сахарын орцтой бөгөөд хүн амын дундаж хэрэглээ нь маш өндөр байдаг аж.


**Монголчуудын 54.4**

**хувь нь илүүдэл жинтэй, 19.7 нь хэт тарган гэсэн судалгаа бий**

Хэт таргалалтад нэрвэгдсэн орнууд үүнийг үр дүнтэй арга хэмээн үзэж, 2011 оноос Финлянд, Унгар, Франц, Хятад, Мексик зэрэг орон нэгдэжээ. Одоогоор чихэртэй ундаанд онцгой татвар ногдуулдаг улсын тоо 20 гаруйд хүрснийг ДЭМБ-ын төлөөлөгч Фиона Булл онцолсон байна. Хамгийн сүүлийн жишээ гэвэл, Нэгдсэн вант улсын парламент

## ЧИХЭРТЭЙ УНДААНААС ШАЛТГААЛСАН НАС БАРАЛТ

Нэг сая насанд хүрэгч тутамд (жилээр)



өнгөрсөн жил 100 гр ундаанд агуулагдах сахарын хэмжээ нь таван гр-аас их байвал татвар ногдуулах төлөвлөгөөг олон нийтэд танилцуулсан юм. Ирэх жилээс хэрэгжих уг татварыг нийт иргэдийн 69 хувь нь дэмжжээ. Түүнчлэн, энэ танилцуулгын дараа чихэртэй ундааны худалдан авалт 132 сая паундаар буурсан байна.

Харин Мексик улсын хувьд 2014 оноос нэг литр чихэртэй

ундаа тутамд 1 песогийн татвар ногдуулж эхэлсэн. Ингэснээр бүтээгдэхүүний үнэ 10 хувиар нэмэгдсэн ч үйлдвэрлэл нь ганц жилийн дотор 12 хувиар багассан байгаа юм.

Зарим хүн татвар нэмэх нь бэрхшээлээс гарах гарц биш хэмээн үздэг. Харин үүнд мэргэжилтнүүд тамхины онцгой татварыг бодит жишээ болгон дурдаж байна. Сахарын хэрэглээ иргэдийн эрүүл мэндэд хор

учруулж буй тул дээрх хоёр барааны араас ийнхүү жагсаж буй.

Чихэртэй ундааны татварыг нэмэхээр үйлдвэрлэгчид үнэ өсгөдөг. Тэд татвар, хэрэглэгчдийн худалдан авах чадварыг тооцон үнэ тогтоодог тул ашиг нь эрс багасаж, олонх нь өөр ашигтай бизнес хөл тавьдаг байна. Гэхдээ Засгийн газрууд энэ татвараас жимсний цэвэр шүүс, сүүн ундааг чөлөөлдөг.

Ингэснээр эдгээр бүтээгдэхүүний үнэ бусад чихэртэй ундаанаас хямд байх нөхцөл бүрддэг аж. Түүнчлэн, ихэнх орон чихэртэй ундаанаас олсон орлогоо эрүүл мэндийн салбарт зарцуулж байна. Жишээлбэл, Нэгдсэн вант улс уг татвараас ирэх онд 520 сая паунд олж, ерөнхий боловсролын сургуулийн спорт хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөдөг буй. Харин Мексикийн хувьд хоёр жилийн хугацаанд энэ татвараас 2.6 тэрбум ам.доллар олж, үүнийхээ зарим хэсгийг сургуулийн усны эх үүсвэрийг сайжруулахад хөрөнгө оруулжээ.

Энэ мэтээр иргэдийн эрүүл мэндийг сүйтгэж буй сахарын хэрэглээг хазарлахад төрийн оролцоо чухал гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. ДЭМБ-аас сахарыг эрүүл бус хэрэглээ хэмээн нэрлэж, дээрх төрлийн татварыг Засгийн газруудад тал талтай хэрэглээг хэрэглээг сайн туршлага юм.

Ийм татвар нь иргэдийн эрүүл мэндийг дэмжихээс гадна улсын төсөвт ч багагүй нэмэртэйг мартаж болохгүй. Нэгэнт иргэд өөрсдөө хэрэглээгээ хянаж чадахгүй байгаа тул ийм үйлдвэрлэл эрхлэгчдэд төр төмөр нүүрээ харуулахад болохгүй зүйлгүй мэт. Нөгөө талаас нь харвал, манайд борлуулж буй ундааны ихэнх хувийг импортын бараа эзэлдэг. Хэрэв сахарын хэмжээ ихтэй бүтээгдэхүүнээс нэмэлт татвар аваад эхэлбэл тодоодын сүү, сүүн бүтээгдэхүүн болон цэвэр жимсний шүүсний үйлдвэрлэлд багагүй дэм болох нь гарцаагүй. Чихрийн шижин, зүрхний шигдээс зэрэг сахарын хэрэглээнээс үүдсэн өвчнөөс иргэдээ сэргийлэх үүрэг төрд оногдож буйг анхаарууштай. [BVM]

## Ил захидал

**Шинээр томилогдсон Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин танаа 2017 оны аравдугаар сарын 20-ны өдөр**

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Менежментийн мэргэшсэн зөвлөхүүдийг бэлтгэдэг “Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо” төрийн бус байгууллагаас шинээр томилогдсон Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин танд хандаж байна.

Бид 2008 оноос үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж буй бөгөөд менежментийн чадварлаг зөвлөхүүдийг мэргэшүүлэх, тэднээр дамжуулан хувийн хэвшлийн байгууллагуудын олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, улмаар Монгол Улсын эдийн засгийг хүчирхэгжүүлэх зорилгоор шинэ санаа, шинэ төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирлээ. Үүний нэг нь Монгол Улсад Олон улсын менежментийн тогтолцооны стандарт (ISO)-уудыг нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд чиглэж байгаа юм. Харамсалтай нь бидэнд олон улсын стандартуудыг Монгол Улсад нэвтрүүлэхэд дараах гурван хүндрэл тулгарч байна гэж үзэж байна. Үүнд:

1. Менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үе шатанд олон асуудал дагуулж буйн нэг нь аж ахуйн нэгжид зөвлөх үйлчилгээ үзүүлж, баталгаажуулалт хийх явцад одоогийн мөрдөж буй MNS стандартууд хэтэрхий хуучирсан байгаа нь тухайн компанийн хөгжилд ихээхэн чөдөр болж байна. Монгол Улсад мөрдөж буй 6000 гаруй стандартуудаас ердөө 35 хувь нь олон

улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд байгаа нь үнэндээ чамалалттай үзүүлэлт юм. Түүнчлэн олон улсын жишгээр аливаа стандарт таван жил тутамд шинэчлэгдэх ёстой. Гэтэл Монгол Улсад энэ үйл явц их удаашралтай явагдаж, тухайлбал, 1988 онд баталсан MNS стандарт өнөө хэр шинэчлэгдээгүй, мөрдөгдөж байна. Аж ахуйн нэгжүүд зах зээлээ тэлж, бүтээгдэхүүнээ экспортлох, үйл ажиллагаагаа олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн тулд олон улсын стандартуудыг нэвтрүүлэх хүсэлтэй байдаг. Тиймээс Монгол Улсад мөрдөж буй 6000 гаруй стандартыг нэн яаралтай шинэчилж, олон улсын стандартад нийцүүлэх талаарх стандартчиллын бодлогыг шинэ түвшинд гаргах шаардлагатай байна.

2. Юуны түрүүнд, менежментийн тогтолцооны стандартаар мэргэшсэн үндэсний зөвлөх, аудитор, сургагч багш бэлтгэхийн тулд эхлээд олон улсын стандартын төрөлжсөн сургалтад хамруулах, үндэсний болон олон улсын хэмжээнд бүртгэлжүүлж, гэрчилгээжүүлэх шаардлага тулгардаг. Монгол Улсад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитор цөөн байгаа учраас олон улсад бүртгүүлэх процессыг дэмжсэн төрийн бодлого дутагдаж байна. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжүүд олон улсын баталгаажуулалтыг хүсч байгаа боловч олон улсын хэмжээнд

нийцсэн баталгаажуулалт хийх аудитор манайд дутагдалтай байгаа нь гаднынханд зах зээлээ алдах нөхцөл болж байна. Тодруулбал, БНХАУ, БНСУ, ОХУ-ын баталгаажуулалтын байгууллага сүүлийн 3-4 жилд Монголын зах зээлд хүч түрэн орж ирлээ. Тэд Монголын томоохон компаниудад өндөр үнээр олон улсын баталгаажуулалт хийж алдах биш дотооддоо авч үлдэхийн тулд энэ төлөгдөхгүй байна. Гэтэл Монгол хүн эх орондоо олон улсын баталгаажуулалтыг хийх чадвартай болж буй энэ үед валютын урсгалыг гадагш алдах биш дотооддоо авч үлдэхийн тулд энэ чиглэлээр дагнасан үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн компаниудыг төрөөс дэмжин үндэсний боловсон хүчнээ чадавхижуулах шаардлагатай байна. Нөгөөтэйгүүр, нэн тэргүүнд Монгол аудиторруудыг олон улсын хэмжээнд бүртгэлжүүлэх шаардлага гарч ирж байгааг дахин онцлон тэмдэглэе.

3. Эцэст нь, Монгол улсад Стандарт, хэмжил зүйн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой ирэх 2018 онд тохионо. Гэсэн ч стандартын салбарын хөгжил зах зээлийн эдийн засаг, өрсөлдөөний өнөө үеийн хурдыг гүйцэхгүй байна. Стандарт, хэмжил зүйн салбар нь хуучны бүтэц, бүрэлдэхүүн, хуучны арга барилаасаа салаагүй байгаа нь энэ салбарт шинэчлэл хийхэд ихээхэн саад болж байна. Олон улсын

жишгээр аливаа итгэмжлэл хийдэг байгууллага нь бие даасан, хараат бус, хөндлөнгийн байх ёстой. Гэтэл манайд төрийн байгууллага нь өөрсдөө стандарт боловсруулж, зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулж, баталгаажуулалт, итгэмжлэл хийж байгаа нь тун явмаг төдийгүй хэт ашиг сонирхлын зөрчилд хүргэх өндөр магадлалтайг харуулж байна. Олон улсад өөрөө өөрийгөө итгэмжилж, баталгаажуулах процесс огтхон ч байдаггүй учир үүнд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Тиймээс өнөөгийн бүтцээ өөрчилж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна. Үгүй бол Стандарт, хэмжил зүйн байгууллагаас гаргасан шийдвэр, баталгаажуулалт олон улсад хүлээн зөвшөөрөгдөж чадахгүйд хүрэхээр байна.

Тиймээс олон улсын стандартыг Монгол Улсад нэвтрүүлж, хөгжүүлэхэд тулгарч буй дээрх гурван асуудлыг анхааралдаа авч, стандартчиллын байгууллагыг олон улсын жишигт нийцсэн бүтэц, чиг үүрэгтэй болгоход Таны дэмжлэг хэрэгтэй байна.

Танд ажлын амжилт хүсье.  
Хүндэтгэсэн,  
Монголын менежментийн зөвлөхүүдийн холбоо  
Имайл: [info@mmca.mn](mailto:info@mmca.mn)  
Web: [www.mmca.mn](http://www.mmca.mn)

### Судлаачийн үг

# Оросын эдийн засгийн өргөс



## Оросын экспортын 70 хувь нь түүхий нефть, газ

**Олхонуд Баярхүү**  
Судлаач профессор

Монгол-Оросын харилцааг шинэ шатанд гаргана, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг ярал-зуулаад өгнө хэмээн бид хичээж буй. Гэхдээ дараах баримтуудыг анхааралдаа аваад дараа нь хамтын ажиллагаагаа төлөвлөнө хэмээн итгэнэ. Энэ бол Оросын өөрийнх нь эх сурвалжуудын мэдээллээс түүвэрлэсэн баримт ба дүгнэлтүүд юм шүү.

### НЭГ. АМЬЖИРГАА ГЭХ НЭГ ӨРГӨС

“Московский Комсомолец” сонин энэ оны наймдугаар сарын 23-ны сайтад “Нищета и бедность - новый тренд “стабильной” России!” хэмээн нийтлэл тавигдсан нь дээрх гаргаа сонгох далим боллоо. Үнэхээр л үгүйрэл, ядуурал Орос орныг нөмөрч байна уу гэх айдас төрүүлнэ. Кремльд болсон Зохицуулах зөвлөлийн хуралдаан дээр ОХУ-ын Шадар сайд хатагтай Ольга Голодец илтгэхдээ Орост ядуурлын доод түвшинд яваа бүр үгээгүй 16 сая хүн байна гэж гэнэт зарлав. Оросууд улам л ядуураад байна, ядуурал эрлийн хурдаар урагшиллаа гэв. Геополитикийн байлдан дагуулалт хийгээд байдаг ард нь орос хүн ядуураад байдаг,

ямар авцалдаа байна гэж Ерөнхий сайдын тэр орлогч хорлонтойгоор асуужээ. Цалингийн харьцуулалт ч хийж үзжээ. Төрийн Думын депутатын шинэ цалин гэдгийг 2014 оны есдүгээр сарын 01-нээс мөрдөж эхэлсэн, тэр нь 420 мянгаас 720 мянган рубль дотор эргэлдэнэ, сардаа шүү дээ. Гэтэл тэр 16 сая орос хүн бол сардаа 4000-аас доошоо цалин, орлоготой нь. Төрийн Думын гишүүд нь тэр их мөнгөө орон сууц, нөхөн олговор, амралтандаа зарцуулахгүй, тэр нь тусдаа улсаас даана. Ер нь ядуу өрх, ядуу хүн гэж хэн бэ гэдэгтээ ч оросууд их эмзэг хандах болжээ. Ерөөсөө 15.5 мянган рублээс доош орлоготойг нь тэгж тооцье гэж нийтгээрээ үзэж буй. Хэрэв тийм тооцоо хийвэл ядуу гэх тодотголтой орос хүн 43 сая болж өсөх ажээ.

“Независимая газета” гэх сонин 2017 оны хаврын нэгэн дугаараас эшлэе. Бас л баахан мөнгөний тооцоо. Иван Леконцев гэдэг судлаачийн үзэж байгаагаар ядуу, орлого багатай гэдэг ангилалд оросын хүн амын бараг 40 хувь нь бүртгэгдэх магадлалтай гэсэн байх юм. Хүмүүсийн орлого ба үнийн өсөлт зэрэгцээд яваад байжээ. Орос хүн ер нь хэдэн рублгийн цалин, хангамж, тэтгэмж авч байх тухай Ерөнхий сайд Дмитрий Медведев өнгөргөж хавар тогтоолд гарын үсэг зуржээ. 2016 оны эцсийн байдлаар бол хүн ам тутамд ногдуулбал дунджаар 9691 рубль гэж гарч байсан байх юм. Ерөнхий сайдын баталсан тогтоолоор 10 466 рубль болох ёстой ба тэтгэвэр гэхэд 8000-аас буухгүй, хүүхдийн мөнгө 9434-өөс буухгүй байх ёстой. Гэтэл инфляци ганцхан жилд зургаан хувиар, хүнсний инфляци таван хувиар өсч, амьжиргааны баталгаажих доод түвшин дөнгөж 2.5 хувиар ахисан дүнтэй байна.



Орост амьдралын түвшин доогуур, хараат бус шүүх гэж байхгүй, төрийн бүтэц, томхон бизнесийн хооронд зааг ялгаа байхгүй, олигархи ба жирийн иргэдийн хооронд аймшигт ялгаа буй.

гараанаасаа эхлээд байгалийн баялгийн олборлолт түшсэн эдийн засгийн хуучин модель түүх болно гэж итгэж байтал байдаггүй. Нефть ба байгалийн хийн экспорт хийдэг улс оронд ДХБ-д гишүүн байх хэрэг алга гэжээ.

“G-20” бүлгийн гишүүд дотроос 2008-2009 оны хямралд хамгийн их өртөж, гадаад худалдааны эргэлт нь унасан улс Орос болжээ. Нүүрс хүчлийн хийн хэрэглээ дэлхийд багассан, түүнд нь Оросын экспорт хэрчигдсэн. Тэр үед ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамыг толгойлж асан Эльвира Набуллина өндөр өртөг шингэсэн бараа үйлдвэрлэж экспортлохыг уриалан, худалдааны тэнцлийн алдагдлаа нөхөхийг

болсон бололтой.

Оросыг түүхий эд экспортлогч гэдэг утгаар ДХБ-д ямагт хоёрдугаар зиндаанд авч үздэг. Улс орнуудын хувьд гадаад зэх зээлд суурь машин, металл, машины эд анги, хөдөлгүүр экспортолдог нь үнэлэгддэг бол Оросын экспортын 70 хувь нь түүхий газрын тос, байгалийн хий. Хэрэв Орос нь машин ба суурь машины экспортоор Германтай өрсөлддөг бол ДХБ-д байгаагийнх нь давуу тал хэрэг болох байлаа. Харин түүхий нефть, газ гаргадаг гэвэл хэнд тоогдох билээ гэх аясаар Александр Мурашов гэх судлаач уулга алдан бичжээ. Орос бол ерөөсөө хөгжингүй орнуудын түүхий эдийн колони боллоо гэх түүний

буруу байна. Улс оронд хүн амын ердөө ганцхан хувь нь л илт сайхан амьдарч байна гэж ирээд хараал урсгасан нь жирийн орос хүмүүсийн нийтлэг бухимдлын тусгал гэж ойлгогдохоор.

Профессор Лев Гудков бичиж байна. Эмиграцын давалгаа Орос орныг нөмөрлөө. Өндөр мэргэжилтэй боловсон хүчин нь ийм олноороо яваад өгөхтэй зэрэг тэр нь эдийн засгийн байдалдаа ноцтой нөлөөлж таарна. ОХУ-ын эрх баригчид иргэний нийгэмдээ таагүй ханддаг, орлого буурсан, нийгмийн социал ялгарал ихэссэн шалтгааныг тэрээр тоочжээ. Түүний ярьснаар бол эх оронд нь авторитари дэглэм бэхжиж хүчирхэгжин,

салбарынхан гэжээ. Академичсан шинжлэх ухааны орчныг төрийн хүнд суртлаас дарамтлаад төсөөр хавчаад өгөхөөр ажиллагсад нь АНУ, баруун биш юм аа гэхэд Хойд Солонгос, Ираны цөмийн эрчим хүчний салбарын өгөөшөнд өөрсдөө гүйгээд орчихно гэсэн үг. Мөн соёл, боловсрол, эрүүл мэндийн аль оллогтой нь эмиграцын гуравдахь давалгаанд нэгджээ.

Энэхүү далан долоон булчирхайг дэлгэгч Гудков бол өөрөө «Левада-Центр» хэмээх судалгаа тандалтын төвийн захирал. Тэрээр санал асуулгад оролцогсдын таван хүн тутмын нэг нь (19 хувь) Орос орноо орхих тухай бодож явдаг гэсэн байх юм. 2015 онд энэ тоо 12 хувьтай



**[ЗГМ СОНИН]**

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойголзол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**

Тэргүүн орлогч эрхлэгч  
**Баатарын ДУЛАМХОРЛОО**  
Утас: 99997481

Орлогч эрхлэгч  
**Лагаважавын СУГАРМАА**  
Утас: 99903584

**РЕДАКЦИ**

Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба  
**Эдитор Б.Даваатогтох**  
Утас: 99901637

Эдийн засаг, уур уурхайн мэдээллийн алба  
**Эдитор Б.Баяртотгох**  
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
**Эдитор Г.Баярсайхан**  
Утас: 99903574

**ЗАР СУРТАЛЧИЛГАА**

**Э.Нхбаатар**  
Утас: 99903578

**ХАЯГ**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, I хороо, Энхтайваны өргөн чөлөө, “Бло Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 70106065

**ЦАХИМ ХУВИЛБАР**  
ubinfo.mn

**Дугаарын удирдагч**  
Б.Энхжаргал

### ХОЁР. ДХБ-Д ОРОС ЭЛСЭНИЙ ХОР УРШИГ

Оросын эдийн засагт нэмэр болох, гадаад худалдааг хөнгөвчлөх талаар бас элдэв сөрөг мэдээлэл Оросоос тасрахаа болилоо. Юу гэвэл Орос нь Дэлхийн худалдааны байгууллагад элсээд таван жилийнхээ ойг саяхан тэмдэглэжээ. 2012 оны зуны адаг сард ОХУ нь ДХБ-ын 156 дахь гишүүн улсаар бүртгэгджээ. Чингэхдээ элсэхийн тулд 18 жил хэлэлцээ хийсэн, ер нь л урт зам туулж, оросын иргэдэд ч их итгэл төрүүлжээ. Гэтэл тэгсний дараа таван жилд Оросын эдийн засаг ба хүн амд нэмэх зүйл авчирсангүй. Учир нь ОХУ-ын хүлээсэн үүрэг нь ахдахаар, эсвэл геополитикийн амбицтай нь зөрчилдөхөөр юм. Гаалийн татварыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бараа, эм эмнэлгийн тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, автомашины импорт дээр багасгана гэсэн амлалтууд Орост үр өгөөж муутай. Хариуд нь ДХБ-ын бусад гишүүд нь оросын барааны импортод хязгаарлалт хийхгүй байх учиртай. Ингэснээр Оросын гадаад худалдаа цэцэглээд, бизнесийн харилцаа өргөжих ёстой байжээ. Гэтэл байдаггүй.

Оросын эдийн засгийн өрсөлдөх чадвар өсч дөвжээд, эдийн засгаа хөхиүлэх ёстой агал энэ таван жилд Оросын эдийн засагт тийм гэгээтэй нөлөө харгадсангүй. Орост эдийн засгийн хориг тавьж, мөн нефтийн үнэ ашиг, рубль девальвац болсноор үр унаж гэж нойл заажээ. Оросын ШУА-ийн профессор Алексей Портанский бичиж байна. ДХБ-д Орос элсэсний хор уршигийг Оросын эдийн засгийн гадаад байдлын шууд тусгал гэж ойлгох ёстой ба тэр нь маш хүнд байна. Оросын албаны нөхөд анхлан ДХБ-тай хэлэлцээ хийхдээ тэгж элсэсэнээр Оросын эдийн засгийн лут реформ

шаардаж байжээ.

Ерөөсөө Оросын эдийн засгийн загварыг өөрчилж, хайтек хөг-жүүлэх, тэгсний дараа л ДХБ-д гишүүнчлэлтэйгээ байгаагийнхаа ид шидийг үзэнэ. Хэрэв анхнаасаа л байгалийн баялгийн олборлолт түшсэн эдийн засагтай байгаагүй бол ДХБ-д байгаагийн давуу тал өдийд мэдрэгдчих байлаа. Одоо таван жилийн нүүр үзлээ. Ашиг юу вэ гэвэл экспортын зарим салбарын тээвэрлэлт дээд хязгаарлалт алга болсон байна. Ганц нэг шинэ зах зээл нээгдлээ. Энэ бол хэдийгээр ОХУ-д хамаатай асуудал мэт боловч уул уурхайн экспорт түшсэн Монголын хувьд ч бас анхаарах ёстой шүүмжлэл мөн.

### “Эмиграцын давалгаа Орос орныг нөмөрснийг зөвшөөрөх цаг болсон”

Оросын өөр нэг эрдэмтэн Александр Кнобель бичиж байна. ДХБ-д элсэснээр нэмэх (плюс) юм ихгүй, харин хасах (минус) нь арвин байна. Орос нь ДХБ-ын өмнө зөндөө үүрэг хүлээсэн боловч түүнд ахиц гарсангүй. Бүтэн 20 жилийн турш бэлтгэж бэлтгэж ДХБ-д элсэсэнэн. Тэгээд ДХБ-аас маш их зүйл хүсэн хүлээсэн нь л гол буруу байжээ.

Зарим мэдээллээс үзвэл Оросын хөдөө аж ахуйд ДХБ дахь гишүүнчлэл хүнд тусчээ. Оросын хувьд тун ашиггүй нөхцөл болзол хөдөө аж ахуйн салбарт нь тавигдсан ба Орос орон хөдөө аж ахуйгаа бараг алдаж дуусч байгаа юм байна. Хэдийгээр хүн ам нь газар тэнгэр шиг их зөрүүтэй ч Швейцарь нь хөдөө аж ахуйн хувьд Оросоос даваад алга

үгс хилтэнтэйгээр сонсогдоно.

Профессор Лев Гудков бичиж байна. Газрын тос, байгалийн хий, түүхий эд экспортолдог эдийн засгийн загвар нь нөөцөө шавхаж дууслаа. Төрийн мэдлийн том корпорациудыг ажиллууснаар түрээсийн ба хамжлагын эдийн засаг үйлчиллээ. Албан бус хувьчлал, цэргийн зардал, цагдаа, дотоодыг аюулаас хамгаалах хүчний зардал зэрэг зэрэг өслөө. Хүн амын тодорхой хэсгийнхнийг дэглэмийн төлөө дуугардаг болгож худалдаж авлаа. Нэр алдар горьдсон янз бүрийн төслүүдийг үүн дээр нэмэх хэрэгтэй. Керчийн хоолой дээгүүрх гүүр, шинэ сансрын буудал, өвлийн олимпын байгууламж гэх мэт. Харин үүнийг нь Оросын эдийн засаг даахгүй байна. Үүнд оросын ард түмэн бүхэлдээ таатай биш хандаж байна гэжээ.

### ГУРАВ. ДАЙЖИЛТ БА ЦАГААЧЛАЛ

Энд цалин, орлого, ДХБ-д элсээд ашиггүй байгаа тухай өгүүлж байвч цаана нь “орос хүн???” гэх асуулт байнга ээрээстэй. Оросоос зөвхөн “супермэргэжилтнүүд” явж одож байгаа бус мэдлэг мэргэжлийн аль ч салбарт өөрийгөө мэргэжсэн гэж үздэг орос хүн болгон гадаадад гарч ажиллахын түүс болсон тухай мэдээлэл их тааралдах боллоо. Цалин хөлсөө чамласандаа биш, хулгай луйвар, авлига нь оросуудыг Оросоос үргээх бодит нөхцөл болдог гэнэ. Израиль рүү Гүрж, Украинаас их дүрвэж гардагтай адил үзэгдэл яг одоо Орост тулгарчээ.

Орост амьдралын түвшин доогуур, хараат бус шүүх гэж байхгүй, төрийн бүтэц, томхон бизнесийн хооронд зааг ялгаа байхгүй, олигархи ба жирийн иргэдийн хооронд аймшигт ялгаа буй. Тэгэхээр иргэншсэн ертөнц рүү оросууд тэмүүлэх нь юуны

түүнээс болж ухаантай, эрдэмтэй, оюунлаг оросууд нь үр хүүхдийнхээ ирээдүйн төлөө санаа зовион Орос орныг орхиж байгаа гэнэ.

Орос орныг эмиграцын гурав дахь давалгаа нөмөрлөө гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг болсон хэмээн Лев Гудков үзэж байна. Энэ нь СССР тарснаас хойшхи гуравдахь нь.

1) Эхнийх нь жүүд, герман гэхчлэн угсаатны зарим бүлгийн төлөөлөөр хэрэгжсэн. 2) Хоёр дахь нь эдийн засгийн реформын хөндүүр үед хэрэгжсэн. ДНБ шалдаа бууж, ажилгүйдэл хавтгайрч, түүнээс болж мэргэжсэн мэргэжсэн үй гүмэн хүн хил даван оджээ.

3) Одоогийн гурав дахь нь 2011 оноос эхэлсэн. Залуувтар, мэргэжилтэй, мөнгөтэй хэсэг нь хилийн чанад дахь элдэв холбоо сүлбээгээ ашиглан гарч одож байгаа. Асар их валкот гадаад руу гаргаж байршуулсан, гадаадад үл хөрөнгө худалдан авсан, улс төрийн шалтгаанаар бус. Гэхдээ Путины дэглэмээс ангид иргэншсэн нийгмийг хүсэгчид нь гурав дахь үеийн эмиграцынхан гэнэ.

Тэд Оросын эдийн засгийн бодлогод сэтгэл гутрагсад. Явж явж СССР-ээс хойшхи 26 жилд ард түмнийх нь хэрэгцээ шаардлага төдийлөн өссөнгүй. Түүнд гутрагсад цагаачлалыг л мөрөөднө. Мэдээж тэгэх хүсэлтэй нь нийгэмдээ ихгүй, цөөхүүдээ. Гэхдээ ноцтой уршигтай. Аль өнгөтэй өөдтэй, боловсролтой, эрдэмтэй, идэвхтэй, хөрвөдөг хэсэг нь гадаад гараад явчихна. Тэднэггүйгээр Орос орон хайран гэж харамсаар. Эрдэмтэн Гудков бүр нарийвчилсан судалгаа гаргажээ. Аль салбарынхан түлхүү цагаачилж байна вэ гэвэл дунд ба жижиг бизнес, инновацын технологи, шинжлэх ухаан. Өөрөөр хэлбэл төрийн зүгээс хэрэв дарамтлал хөгжил нь зогсчих тийм

байсан байна. Санал асуулгад харилсан орос иргэдийн 26 хувь нь баруунд байнга цагаачлахгүй ч байнга ирж очиж, зугаацаж, болж өгвөл тэндээ данстай, ядаж л үр хүүхдээ сургуульд илгээгээд байх хүсэлтэй гэсэн байх юм. Хэдэн жилийн өмнө энэ тоо 19 хувьтай гарч байсан гэж байна.

Баруун руу тагагдах оросуудын хусулийн нь цаад шалтгаан юу вэ гээд асуухад хилийн чанад дахь аз жаргалтай амьдрал хэмээн ихэнхи нь харуулжээ. Оросын дотоод байдлаас боллоо, Орост тааруухан байна гэсэнтэй адил чихнээ бууж байна. Барууныхны сайн сайхныг тоочсон явдал ч бас байна. Амьдралын таатай нөхцөл, материаллаг хангалууны дээд түвшин, экологи, эмнэлгийн үйлчилгээний давуу тал, ямар ч л гэсэн аюулгүй, хөвүүдийг армисаас чөлөөлж болдог давуу тал гэхчлэн ярайлгажээ.

Дмитрий Орешкин гэж эрдэмтэн энэ талаар бас баахан юм ярьжээ. Хүн амынх нь 20 хувь дээд боловсролтой гэж үзвэл харин тэдний 40 хувь Оросоос явах хүсэлтэй гэсэн байх юм. Хэдийгээр эх оронч нь дэндчихсэн, барууныг нэг нүдээрээ ч үзэж чаддаггүй орос хүн байлаа гэхэд яг тулаад ирвэл баруун руу тэмүүлэгч байдаг. Тэр нь ахуйн нөхцлөөс болдог гэсэн байх юм. Ахуй анхдагч учраас тэр юм гэнэ. Сэтгэл гутралд орчихсон, улс орноо хараагаад суудаг, сонгуульд санал өгдөггүй, тэгсэн мөртлөө Оросоосоо явдаггүй хүн олон байдаг бололтой юм. Тиймүүдэд нь ч хамаатан садан, ирдэг очдог гээд гадаадтай холбоотой хүн бас олон болсон. Зөвлөлт Холбоот Улсаас гадаадад гарах гэж хангалттай зөвлон туулаад нэг гарвал эргэж ирэхээргүй болдог байсныг бодоход өнөөгийн Орост гарч яваад, эргэж ирээд, нутаг сэлгээд аж төрөөд байх нөхцөлд бүрдсэн нь гол давуу тал хэмээн Орешкин ярьжээ.

## Зах зээл



Командын сургалтын үнэ нохойны үүлдэр, гарал угсаа, сэтгэл зүйн байдлаас шалтгаалаад 300-500 мянган төгрөг байдаг аж. Нэг удаагийн сургалт 14-45 хоног бөгөөд зарим үед 60 хоног хүртэл үргэлжилдэг.

С.Батсайхан / ЗГМ

# Тэжээвэр амьтдыг тойрсон мөнгөний эргэлт

**Бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт 96 тэрбум ам.долларт хүрнэ**

Г.Оюунтөгс  
@oyuntugsZGM

Гэрийн тэжээвэр амьтан тэр дундаа нохой тэжээх хандлага сүүлийн жилүүдэд эрс нэмэгджээ. Өдгөө нохойны үнэ үүлдэр, гарал үүслээсээ шалтгаалаад 150-1.6 сая ам.долларт хүрээд байгаа аж. Тодруулбал, Их Британийн эзэн

хааны нохойн үүлдрийн нохой хамгийн үнэтэйд тооцогдож байна. Эдийн засгийн хямралаас үл хамааран гэрийн тэжээвэр амьтантай холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт 81 тэрбум ам.долларт хүрээд буйг “Packaged Facts” судалгааны компаниас мэдээлжээ.

АНУ-ын нийт өрхийн 56 хувь нь тэжээвэр амьтантай байдгаас 38 орчим хувь нь нохой тэжээдэг аж. Иймээс АНУ-ын гэрийн тэжээвэр амьтан, тэр дундаа нохой, муурны хоол, эдлэл хэрэгсэл болон төрөл бүрийн үйлчилгээний зах зээл хүрээгээ тэлээд буй. Учир нь тэжээвэр амьтдад зориулсан эмнэлэг, дэлгүүр, усанд оруулж, алжаал тайлах төв, өдөр

өнжүүлэх, сургалт, хөгжлийн төв, гоо сайхан, гадаад үзэмжид зөвлөгөө өгөх газрууд элбэг. “Packaged Facts” зах зээлийн судалгааны байгууллагын мэдээлж буйгаар 2020 он гэхэд дээрх тоо 96 тэрбум ам.долларт хүрэх аж.

### ӨДӨРТ 25-100 МЯНГАН ТӨГРӨГИЙГ НОХОЙНД ЗАРЦУУЛДАГ

Харин Монгол Улсад гурван хүн тутмын нэг нь гэрийн тэжээвэр амьтантай гэсэн албан бус тоо бий. Улаанбаатар хотын хэмжээнд гэхэд 60 орчим мянган гэрийн тэжээвэр нохой байдаг аж. Өнөөдөр Монгол Улсад худалдаалагдаж буй нохойны үнэ үүлдэрээсээ шалтгаалаад 100 мянгаас нэг сая төгрөгт

хэлбэлзэж буй. Нохойнд зарцуулагдах нэг өдрийн зардал 25-100 мянган төгрөг. Эдгээр мөнгө нь хоол, сургуулилт, витамин, эмчийн үзлэг зэрэгт зарцуулагддаг аж.

Төлбөр хураамжийн хувьд гэр хорооллын нохой тэжээдэг өрхөөс ямар ч хураамж авдаггүй бол орон сууцанд амьдардаг иргэд 1000-5000 төгрөгийг СӨХ-д тушааж буй. Харин нохойны гэрчилгээг тухайн худалдан авч буй газраасаа авдаг аж. Энэ мэтчилэнгээр тэжээвэр нохойг бүртгэлжүүлж, баримт бичигтэй болгож буй нь нохойны зах зээл бүрэн утгаараа хөгжиж буйн тод жишээ юм. Энэ төрлийн бизнес хөгжиж буйн бас нэгэн жишээ нь нохой сургагчдын эрэлт. Тодруулбал, таны нохойд суух, босох, эргэлдэх, харайх гэх мэт үйлдлийг эзний тушаалаар гүйцэтгэдэг байх. сургалтыг олгодог мэргэжлийн хүмүүс бий болжээ.

Тушаал ойлгуулж, биелүүлдэг байх сургалтын үнэ нохойны үүлдэр, гарал угсаа, сэтгэл зүйн байдлаас шалтгаалаад 300-500 мянган төгрөгийн хөлстэй. Нэг удаагийн сургалт 14-45 хоногийн хугацаанд үргэлжилнэ. Тэгэхдээ зарим тохиолдолд 60 хоног хүртэл үргэлжлэх нь ч бий. Тухайлбал хүмүүсийн мэддэгээр хаски, бетховен, голден, спанел зэрэг нохой төрөлхийн тайван сэтгэл зүйтэй бөгөөд үнэрлэх мэдрэмж хамгийн сайн хөгжсөн байдаг. Тиймээс тушаал биелүүлж сурахдаа хойрго, удаан. Харин авчарка нохой эсрэгээрээ байгалийн зөнгөөрөө дайчин, сэргэлэн, хурдан хөдөлгөөнтэй байдаг тул энгийн болон тусгай тушаалыг хамгийн хурдан хугацаанд биелүүлж сурдаг аж. Тиймээс хэрэв нохой тэжээхээр зэхэж байгаа бол гаднах үзэмжинд хууртагдалгүй үүлдэр, гарал угсаа, сэтгэл зүйн байдлыг нь судалж байж сонгох шаардлагатай гэдгийг нохой сургагчид онцлов.

Нохой сургагч Б.Норовням “Сүүлийн жилүүдэд нохой сургалтын эрэлт нэмэгдэх болсон. Би дунджаар сард 1-2 нохой сургадаг. Гаднын орнуудад нохойны үнэ харьцангуй өндөр байдаг. Энэ нь гудамжны буюу золбин нохойны тоог олшруулахгүй байх сайн талтай. Нэг ёсондоо үнэхээр цаг хугацаа, хөрөнгө мөнгөө зарцуулж чадах, эсэхэд шалгуур тавьж байгаа юм. Иймээс командын сургуулилын үнэ болон бусад зардал нь ч дагаад нэмэгддэг” гэв.


Өнөөдөр цахим орчинд гэрийн тэжээвэр амьтдыг хамгаалах, өсгөж үржүүлэх, худалдаалах фэйсбүүк хуудас олширч, хүмүүсийн хандалт тэр хэмжээгээр нэмэгдэж буй. Цахим хуудаснаа нийтэлсэн мэдээллээс харахад Улаанбаатар хотод цөөн тооны нохой усанд оруулдаг газар буюу спа, эрүүл мэндэд нь анхаарал тавих 10 орчим улсын

### ЗГМ: ИНФОГРАФИК

## Гэрийн тэжээвэр амьтдын зах зээл

ДЭЛХИЙН НИЙТ ХҮН АМЫН 57% НЬ ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАН ТЭЖЭЭДЭГ


#### АМЬТДЫН ЭЗЛЭХ ХУВЬ:



#### ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН:



#### ХАМГИЙН ОЛОН ТЭЖЭЭВЭР АМЬТАНТАЙ УЛС: (ХҮН АМД НОГДОХ)



#### АМЬТАН ТЭЖЭЭДЭГ ХҮМҮҮСИЙГ ХҮЙСЭЭР НЬ АВЧ ҮЗВЭЛ:



Тэжээвэр амьтны үйлчилгээ эрхлэгчдийн орлого **55.7-81** тэрбум ам.долларт хүрчээ.

#### ФРАНЧАЙЗИНГ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЭРГҮҮЛЖ БҮЙ УЛС ОРНУУД: (САЯ АМ.ДОЛЛАР)



“Packaged Facts” company

болон хувийн эмнэлэг, дэлгүүр үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн дээрх тоотой дүйцэхүйц хэмжээний цахим худалдааны вэб сайт бий. Эдгээр вэб сайтад бүх төрлийн зүйл худалдаалдаг бөгөөд нохойны хүзүүвч чанар хийцээсээ шалтгаалаад дунджаар 8-40 мянган төгрөг байдаг байна. Өнөөдөр дэлхийн

гэрийн тэжээмэл амьтны зах зээл маш хурдацтайгаар өсөж байгаа бөгөөд хэд хэдэн улс орон эзэмшлээсээ үл хамааран гэрийн тэжээвэр амьтны амьжиргаа зардал хувь хүнийхээс хэд дахин өндөр байгаа юм.

Тэгвэл тэжээвэр амьтдын зах зээл бизнес эрхлэгчдэд ашигтай байх боломжтой. [ЗГМ]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017оны 10 сарын 20- ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Олон улсын нислэгийн зорчигчдын үйлчилгээнд архи, дарс, шар айраг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 3 багц бүхий нээлттэй тендер**

- Багц 1:** 6 нэр төрлийн архи нийлүүлэх /50мл хэмжээтэй савласан/
- Багц 2:** Дарс нийлүүлэх /0.75л савласан/
- Багц 3:** Шар айраг нийлүүлэх /0,33л савласан/

Тендер шалгаруулалтын дугаар: **32/2017-М**  
“МИАТ” ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос **“Олон улсын нислэгийн зорчигчдын үйлчилгээнд архи, дарс, шар айраг нийлүүлэх”** битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК –ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, 103 тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ сүүлийн 2 жилд: 300 сая төгрөгнөөс багагүй, Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:Багц 1-т 150 сая төгрөгнөөс багагүй, Багц 2-т 400 сая төгрөгнөөс багагүй, Багц 3-т 120 сая төгрөгнөөс багагүй
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2015, 2016 он
- Сүүлийн 2 жилд ижил төстэй гэрээг хамгийн багадаа 1 удаа гүйцэтгэсэн байх бөгөөд тус гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Тендерийн хамт 1-р багцад 4,505,200 төгрөгийн, 2-р багцад 12,190,000 төгрөгийн, 3-р багцад 3,400,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 11 сарын 20-ны өдрийн 09 цаг 00 минут–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 11 сарын 20- ний өдрийн 09 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлж болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа дахь, МИАТ ХК –ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө, Утас: 70049860, Факс: 70049919

### ХӨТӨЧ

## Нохойнд зориулсан үйлчилгээ дэлхий дахинд тархжээ

**CAMP BOW WOW**  
Өдөр болон шөнийн дотуур байр, сургалтын үйлчилгээ үзүүлдэг. Тус байгууллага нь 2003 онд байгуулагдсан бөгөөд өдгөө дэлхийд 100 гаруй салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нэг салбар нээхэд 600 мянган ам.доллар зарцуулдаг.

**DOGTOPIA**  
Шөнийн цагаар нохойнд зориулсан дотуур хувцас, үс засалт, сургалт, жижиглэн худалдааны бүтээгдэхүүнийг санал болгодог. Анх 2005 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 31 салбартай болжээ. Тус бизнесийг эхлүүлэхэд 318-497 мянган ам.доллар шаардлагатай.

**FETCH**  
Гэрийн тэжээвэр амьтанд биеийн бүх төрлийн арчилгааны үйлчилгээ эрхэлдэг. Дэлхийн

1500 гаруй хотод үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү үйлчилгээг эрхлэхэд 30-45 мянган ам.доллар зарцуулдаг.

**BUTLER**  
Гэрийн тэжээвэр амьтдын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах үйлчилгээг санал болгодог байгууллага. 1988 оноос хойш үйл ажиллагаа явуулж эхэлжээ. Энэ төрлийн бизнесийг шинээр эхлэхэд 45-60 мянган ам.доллар шаардлагатай.

**PETLAND**  
Гэрийн тэжээвэр амьтдын салбарт 45 жилийн туршид үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь өдгөө 500 гаруй салбарыг дэлхийн өнцөг булан бүрт нээжээ. Салбар нээхэд байршлаасаа шалтгаалаад 300-900 ам.доллар зарцуулагддаг аж. [ЗГМ]

## ЗГМ: Зочин

## Бид өөрсдийн чадал, боломжинд таарсан наадмуудыг зохион байгуулах ёстой

**Монголын жүдо бөх дэлхийд тэргүүлэх зэрэгт хүрээд байна**

◀

Одоо хашиж байгаа алба нь Украины УОХ-ны ерөнхийлөгч, ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, Олон улсын хөнгөн атлетикийн холбооны тэргүүн дэд ерөнхийлөгч. Ялангуяа гимнастик, каное завь, бөхийн төрлүүд, бокс, сагсан бөмбөгөөр цуутай тамирчдыг төрүүлсэн баялаг уламжлалтай орон. ЗХУ-аас тусгаар тогтносны дараа амжилт нь тодорхой хэмжээнд буурсан ч одоо эргээд сэргэж байна. Өнгөрсөн 2016 оны олимпод 200 гаруй тамирчнаа оролцуулна гэдэг спортын том гүрнүүдийн хэмжээний үзүүлэлт.

Монголд хөгжиж буй спортын төрлүүд Украинд сайн хөгжсөн байдаг. Тэгэхээр бид ийм орнуудтай маш сайн хамтарч ажиллах ёстой. Хуучин ЗХУ-ын үед спортын анагаах ухааны чиглэлийн украин гаралтай эрдэмтэд их байв. Цаг ямагт сайн дасгалжуулагчдыг төрүүлдэг уламжлал нь одоо ч хэвээр байна. Мөн Олимпын академийн хүчтэй ажилладаг. Украины энэ давуу талуудаас суралцахын тулд бид хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

Гэрээний хүрээнд спортын зарим төрөл дээр тамирчин, дасгалжуулагч солилцох асуудал багтсан. Нөгөө талаар спортын шинжлэх ухааны чиглэлээр мэргэжилтнүүдийг авчирч, сургалт семинар зохион байгуулна. Спортын хөгжил, тамирчдын бэлтгэлжилтийн түвшинд чухал нөлөө үзүүлдэг нэг гол хүчин зүйл бол спортын сургалт дасгалжуулагчдын төлөвлөлт, боловсруулалт юм. Хамгийн гол нь бид спортын төлөвлөлтөд анхаарч, тэр чиглэлээр мэргэжилтэн урих сонирхолтой байна. Мөн олимпын хөдөлгөөнийг улс орон даяар хөгжүүлэх талаар Украины туршлагаас суралцах, санаа авах зүйл их бий.

#### АЗИ ТИВИЙНХЭНД ҮНЭЛЭГДЭХ БОЛОМЖ НЭЭГДЭЭД БАЙНА

**-Азийн танхимын болон тулааны спортын наадам Туркменистаны Ашгабат хотод болж, Монголын тамирчинд түүхэнд дэх хамгийн өндөр амжилтаа үзүүллээ. Энэ наадмаас ямар дүгнэлт хийсэн бол. Ер нь олон улсын наадам зохион байгуулахад төлөвлөж байгаа манай оронд хэрэгтэй ямар туршлага "Ашгабат-2017"-оос харагдав?**

-Өнөөдөр манай тамирчин гадагшаа тэмцээнд явахад медаль авахгүй төрөл гэж байхгүй болжээ. Монгол хүн өөрөө спортолог шинж чанартай, авьяаслаг байдаг нь үүнтэй холбоотой байх. Багахан дэмжлэг үзүүлэхэд л амжилт дорхноо гараад ирдэг. Сая танхимын болон тулааны спортын наадамд мөн л сайхан амжилт үзүүлээ. Илүү туршлагатай болоод ирэхийн цагт манай тамирчин төрөл тус бүрт жигд өндөр амжилт гаргах бололцоотой байгаа нь олон жишээнээс тод харагдсан.

Олон улсын наадам зохион байгуулах туршлагын тухайд онцолж дурдмаар зүйл байна. Улс орны нэг хот суурин, нэг бүс нутаг спортоор дамжин хөгждөг. Ашгабат хотыг харахад спортыг хөгжлийн нэг тулгуур багана болгож чадсан нь анзаарагдсан. Тэнд спортын маш том бүтээн байгууллагууд хийсэн байна. Долоон жилийн өмнөхтэй харьцуулахад Ашгабат танигдахын аргагүй хот болжээ гэж мэддэг олон хүн нь хэлж байсан. Нутгийн ард түмэн ч энэхүү сайхан өөрчлөлтөд сэтгэл хангалуун байна лээ. Зохион байгуулагчид ч наадамд маш их ач холбогдол



С.Батсайхан / ЗГМФ

өгсөн нь илт мэдэгдэж байлаа. Азийн 45 улсаас гадна далайн орнуудыг нийлүүлээд 63 улс оруулах жишээтэй. Тамирчдад зориулсан хоол хүнсийг бэлтгэхэд гаднын шилдэг тогоочдыг урьж ажиллуулсан. Монголоос гэхэд 17 тогоочийг шалгаруулж авсан. Монголдоо нэртэй зочид буудлын тогооч нарын олонх нь очсон байна лээ.

Мэдээж амжилт сайн байсан ч бид цаашид юунд анхаарах ёстой вэ гэдэгтээ дүгнэлт хийх ёстой.

#### Украины давуу талаас суралцахын тулд бид хамтын ажиллагааны гэрээ байгуулсан

**-Спортоор дамжуулж улс орноо хөгжүүлнэ гэсэн санаа тун сонирхолтой санагдлаа. Манай Улаанбаатар хотын тухайд үүнийг хэрэгжүүлэх ямар боломж байна вэ?**

-Спортоор дамжуулж хотоо хөгжүүлэх жишиг аль ч улсад байдаг. Манайд ийм боломж бүрэн бий. Бид Азийн наадам, Зүүн Азийн наадам, Азийн танхимын наадам, Азийн хүүхдийн наадам гээд өөрсдийн боломж, чадалд тохирсон наадмуудыг нутагтаа зохион байгуулах ёстой. Үүний тулд мэдээж бүтээн байгуулалтын ажлаа сайн хийж, боловсон хүчнээ бэлдэх шаардлагатай. Тив, бүсийн хэмжээний ийм наадмууд улс орныг сурталчлах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүн амьдрах таатай орчин бий болгох гээд олон талын ач холбогдолтой.

Эрүүл мэндийн яамны санаачилгаар Монгол Улс 2020 онд Азийн хүүхдийн наадмыг зохион байгуулна. Мөн Зүүн Азийн залуучуудын наадмыг 2023 онд Улаанбаатар хотод хийхээр гэрээ байгуулсан. Энэ бол спортоор дамжуулж нийслэл хотоо хөгжүүлэх ажлын эхлэл юм. Олон манлай тамирчдыг төрүүлдэг гэдгээр нь гадныхан Монгол улсыг мэддэг. Сүүлийн жилүүдэд илүү их мэддэг болсон. Тэгвэл Монголын ард түмэн олон улсын наадмыг өндөр хэмжээнд зохион байгуулдаг гэдгээрээ Ази тивийнхэнд үнэлэгдэх боломж нээгддэг байна. Одоо бид хүчээ нэгтгэж, зохион байгуулах хороогоо байгуулж, бүтээн байгуулалтаа үе шаттай хийж, залуучуудаа сургаад явах нь хамгийн чухал.

Наадмын бүтээн байгуулалт болон зохион байгуулалтад мэдээж багагүй зардал гарна. Гэхдээ эдгээр бүтээн байгуулалт улс орондоо үлдэнэ, үүн дээрээ түшиглэн дараа дараагийн тэмцээнийг үе шаттай зохион байгуулах боломж бүрддэг. Ашгабат хот л гэхэд тухайн спортын төрлүүдийн дэлхийн

аваргын тэмцээнүүдийг жил алгасалгүй зохион байгуулна гэж байна лээ. Энэ нь эргээд улс орондоо ашиг авчрах юм. Олон мянган тамирчдаас гадна тэмцээнийг үзэх гэсэн жуулчид ирнэ. Үүнийг дагаад үзвэр үйлчилгээ, зочид буудал, агаарын тээврийн салбар гээд олон салбарт хөгжил дэвшил ирж, ашиг орлого нэмэгдэх гээд олон талын ач холбогдолтой.

**-Сүүлийн үед спорт, олимпизмын үйл хэрэг, үзэл санаа ямар чиглэлд явж байна вэ. ОУОХ-ны ерөнхийлөгч Т.Бахын дэвшүүлсэн хөтөлбөрүүд юунд илүү анхаарч байгаа бол**

-2013 онд ОУОХ-ны ерөнхийлөгчөөр Томас Бах томилогдсон. Түүний хийж, хэрэгжүүлж байгаа ажил нь цэвэр тамирчдыг дээдлэх, шударга өрсөлдөөнийг бий болгоход чиглэж байгаа. Түүнийг ерөнхийлөгч болсноос хойш допингийн эсрэг тэмцэл илт идэвхжээнийг хүмүүс анзаарсан байх. Одоогийн хууль дүрэм, хяналтаа чангатгахад гадна урьд өмнө нуун дарагдаад өнгөрсөн допингийн хэргийг илрүүлэх гээд их ажил хийсэн.

Хоёрдугаарт, олимпын үнэт зүйлсийг хамгаалахад ач холбогдол өгч байгаа. Гуравт, найрамдал, нөхөрлөлийг бий болгоход анхаарч, жил бүр Монакод болдог Олон улсын Энхтайван ба спорт форумд анхаарлаа хандуулж байна. Мөн дайн тулааны хөлд нэрвэгдсэн дүрвэгсдийн урсгалыг зогсоох, тамирчдыг дүрвээд очсон газар нь тэмцээн уралдаанд ялгаварлалгүй оролцуулдаг байлгахад анхаарлаа хандуулсан. Бүр дүрвэгсдийн баг хүртэл байгуулж, дүрвэгсдэд зориулсан тодорхой хэмжээний хөрөнгө гаргасан.

**-ОУОХ допингийн хяналт шалгалтад анхаарлаа хандуулсан гэж та хэллээ. Тэгвэл МҮОХ энэ чиглэлд ямар ажил хийж байна вэ?**

-ОУОХ-ны чиг үүрэг, бодлогыг хэрэгжүүлж, дагаж явах ёстой газар бол тухайн улс орны УОХ. Бид ч бас ОУОХ-ны чиглэлийн дагуу допингийн эсрэг хийх тэмцэлд анхаарч байгаа. Цэвэр тамирчин заавал байх ёстой. Тиймээс спортын холбоод, Допингийн эсрэг үндэсний төвтэй хамтраад допингийн сургалтууд сайн явуулах, тэмцээний бус шинжилгээ авах тал дээр анхаарч байна. Тамирчин хүнийг зөвхөн тэмцээнд очиход нь л шинжилгээ авах биш, бэлтгэлийн үеэр ч бас авах ёстой. Энэ бол Монголд шинээр хэрэгжиж буй ажил байгаа юм.

**-Ер нь Монголын спортын нэр хүнд өнөөдөр олон улсын тавцанд ямар түвшинд хүрээд байна вэ. Олон улсын томоохон удирдлагууд бидний талаар юуг илүү сонирхож байна?**

-ОУОХ гишүүн бүх орноо олимпын хөдөлгөөнд жигд оролцуулахыг зорьдог. Үүний дагуу МҮОХ оролцох ёстой бүх

арга хэмжээнд идэвхтэй оролцоод явдаг. Ер нь үйл ажиллагаа нь идэвхтэй орны тоонд Монгол Улс ордог. Тамирчдын амжилт сайн байгааг бүх л улс орны төлөөлөгчид үнэлдэг. Манай тамирчин амжилт гаргах тоолонд гадныхан монголчуудын талаар илүү ихийг мэдэх эрмэлзэлтэй болж байгааг нь анзаарагддаг. Ялангуяа Монголын жүдо бөх дэлхийд тэргүүлэх зэрэгт хүрээд байна. Гаднын спортын зүтгэлтнүүд, мэргэжилтэн дасгалжуулагчидтай уулзаж байхад "Танай жүдо сайн байна шүү. Жүдоогоос чинь яаж суралцах вэ?" зэрэг яриа их өрнөдөг. Зарим нь бүр шалгаагаад зогсох ч тохиолдол гарна. Энэ бүхэн бол Монголын жүдо бөхийн холбоо маш сайн менежменттэй ажиллаж байгаагийн тод илрэл юм.

#### БИДНИЙ АЖЛЫН ҮР ДҮН ТОКНОГИЙН ОЛИМПОД ХАРАГДАХ ЁСТОЙ

**-Монголчууд спортын талбарт амжилт гаргахын хэрээр гадныхан манайхныг нарийн судлах болсон. Зарим нь ирж тусгай нэвтрүүлэг хийж байна. Ер нь Монголын тамирчдын бусдаас ялгарах ямар онцлогтой вэ. Үүнийг генетикийн талаас тайлбарлавал илүү сонирхолтой байх.**

-Энэ талаар манай эрдэмтдийн хийсэн судалгаа бий. Энэ судалгаагаар монголчууд ганцаарчилсан, халз тулааны төрөлд илүү амжилт үзүүлэх боломжтой гэж тодорхойлсон байдаг. Энэ дүгнэлт үнэний хувьтай гэдэг нь манайхны амжилт гаргаж буй төрлөөс тодорхой харагддаг. Дасан зохицох чадвар, биений хүчний суурь хөгжил, тухайн нөхцөлд тохируулж зөв шийдвэр гаргах ухаан гээд спортын салбарт ч төдийгүй өөр бусад салбарт ч амжилт авчрах бүхий л ур ухаан Монголын тамирчдад бий. Гагцхүү өөрсдөө хүчин зүтгэл гаргаж чадвал амжилт гаргаж чадахгүй спорт гэж монголчууд бидэнд байхгүй.

**-МҮОХ-ноос гадна БСШУСЯ гэж спортын боллого тодорхойлдог том байгууллага бий. Гэхдээ сүүлийн үед сайд нар нь ойр ойрхон солигддоо. Ер нь улс төрийн тогтворгүй нөхцөл байдал спортод хэрхэн нөлөөлж байна вэ?**

-МҮОХ тогтолцооныхоо хувьд төрийн бус байгууллага, төрөөс ямар нэг санхүүжилт авдаггүй. Тамирчдад очиж байгаа санхүүгийн дэмжлэг дандаа төрийн байгууллагаар дамждаг юм. Сайд дарга олон солигдож байгаа нь мэдээж таатай зүйл биш. Гэхдээ МҮОХ-ны үйл ажиллагаанд айтгар нөлөөлсөн зүйл алга. Төрийн болоод төрийн бус байгууллагууд өөр өөрсдийн дүрэмд зааснаа хийгээд явахад л бүх зүйл болно.

**-МҮОХ олимпод бэлтгэгдэж буй тамирчдыг тусгай хөтөлбөрт хамруулж, дэмжиж байсан.**

Миний үндсэн мэргэжил спортын эмч. Тиймээс санаа зовохгүй нэг ч өдөр байдаггүй зүйл бол спортын анагаах ухаан.

их ойрхон байна. Эрх авах тэмцээнүүд ирэх жилээс эхэлнэ. Бид Риогийн олимпод хамгийн олон тамирчнаа оруулсан бол Лондонгоос хамгийн олон буюу таван медаль хүртсэн. Харин Бээжингийн олимпоос хоёр алтан медаль авсан. Эдгээр амжилтаа ахиулах ёстой.

МҮОХ-ны зүгээс тамирчдын бэлтгэлжүүлэлтийн шинжлэх ухааны тал дээр илүү анхаарья гэж бодож байгаа. Тиймээс сая Украины олимпын хороотой багагүй яриа хэлцэл өрнүүлээ. Ирэх оны тавдугаар сард Украинаас боллого, төлөвлөлтийн тал дээр мэргэшсэн хүмүүс ирж, бидэнтэй уулзалт хийнэ. Энэ үеэр бидний одоогийн төлөвлөлт болж байна уу, цаашид юун дээр анхаарах вэ гэдгээ тогтох юм. Мөн Солонгосын допингийн эсрэг төвтэй гэрээ байгуулсан. Энэ чиглэлээр сургалтаа эрчимжүүлнэ. Тамирчдын маань амжилт сайн байгаа. Гэхдээ өөрөө мэдэхгүйгээс болоод допингийн төрлийн эм хэрэглэж, хайран хөдөлмөрөө үгүй болгохгүйн тулд бид үүнд анхаарлаа хандуулах ёстой. Сая гэхэд Олон улсын хүндийг өргөлтийн холбоо допингийн хэргээр арваад орны тэмцээнд оролдох зүйлийг хаслаа. Үүнтэй адилхан эрхий тохиолдвол хэцүү шүү дээ. Бас Японы талтай хамтарсан бэлтгэл хийхээр манай спорт холбоод болон БТСГ ярилцаж байгаа. Энэ бүх ажлын үр дүн Токиогийн олимпод харагдах учиртай.

**-Та анагаах ухааны чиглэлийн хүн. Спортын анагаах ухаан Монголд ямар түвшинд байна вэ. Бид илүү өндөр түвшинд гарахын тулд юу хийх ёстой вэ?**

-Миний үндсэн мэргэжил спортын эмч. Энэ чиглэлээрээ эрдмийн цол зэрэг хамгаалж байсан. Тиймээс санаа зовохгүй нэг ч өдөр байдаггүй зүйл бол спортын анагаах ухаан. Монголын тухайд спортын анагаах ухаан өндөр түвшинд хүрсэн гэж хэлж чадахгүй нь. Спортын анагаах ухаан дэлхийд олон чиглэлээр явж байна. Бэртэл гэмтлийг богино хугацаанд эмчлэх, нөхөн сэргээлтийг хурдацтай явуулах тал дээр маш өндөр түвшинд хөгжсөн. Энэ чиглэлийн тоног төхөөрөмж ч их байна. Мөн тухайн тамирчдын бэлтгэл сургуулилт тохирч байна уу гэдгийг хянадаг тогтолцоо өндөр түвшинд хүрээд байна. Тухайлбал, өнөөдөр чиний бэлтгэл хэтэрсэн байна, эсвэл дутууджээ гэдгийг хэлж өгдөг зүйл нь спортын анагаах ухаан юм.

Сүүлийн үед спортын анагаах ухаан тамирчдын сонголт дээр маш том үүрэгтэй оролцдог боллоо. Тамирчин болох гэж байгаа хүүхэд аль төрөлд амжилт үзүүлэх магадлалтай вэ гэдгийг бид биений ерөнхий байдлыг харж байгаад тодорхойлдог. Харин спортын анагаах ухаан хөгжсөнөөр тухайн хүний үс, хөлснөөс шинжилгээ авсны үндсэн дээр тодорхойлдог болчихсон. Энэ мэтээр дотроо салж байгаа хэсэг болгон дээр бид анхаарч, бэлдэхгүй бол болохгүй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд МҮОХ төлөвлөлт гаргаж, энэ жил зарим ажлаа эхлүүлсэн. 2019 он гэхэд гайгүй түвшинд хүргэчих бололтой.

Өндөр хөгжилтэй гадны орныг харахад ямар нэг тэмцээнд судалгааны бүтэн багтай явдаг. Энэ баг тамирчдын тэмцээнд оролцож буй бүх байдал судалгаа хийж, оноод танилцуулдаг. Эндээс алдаа оноогоо харах боломжтой. Манайд ийм тогтолцоо яах аргагүй хэрэгтэй. Одоо бол зардал мөнгөнөөс шалтгаалаад нэг эмч явахтай, үгүйтэй л байна. Цаашдаа эмчээс гадна дор хаяж хоёр судлаач явуулж, судалгаа шинжилгээ хийж байж өндөр түвшинд гарах учиртай. Би өөрөө спортын эмч мэргэжилтэй хүний хувьд үүн дээр түүхүү анхаарах бололтой байгаа.

**-Ярилцсанд баярлалаа. [ЗГМ]**

# ZGM ENGLISH

## ZGM: HIGHLIGHTS

### POLITICS

The State Great Khural has confirmed the 12 candidates of the ministers as members of the new cabinet.

President Battulga Khaltmaa of Mongolia congratulated Kyrgyz president-elect Sooronbai Jeenbekov on his victory in Kyrgyzstan's historic vote.

### ECONOMY

According to the leading rating agencies, Oyu Tolgoi and Tavan Tolgoi mining projects will contribute to boost economic growth. Therefore, they rated the state's credit outlook "sustainable".

Shares of Mongolia-focused explorer Kincora Copper Ltd added over 9% on Tuesday as it kicked off ground magnetic and gravity surveys at its Red Well license. (with line chart share price/1month)

### Share price of Kincora Copper (1Month)



### SOCIETY

Taiwanese Government donated 230 wheelchairs to people with disabilities at the Rehabilitation and Training Center at the Ministry of Labor and Social Protection.

# Mongolia announces tender offers for USD 2018, CNY 2018 bonds

**Baigal Ganbold, Tselmeg Zorig**

Mongolia announced tender offers for its USD and CNY sovereign bonds which are due in next January and May. The Government of Mongolia is offering 1003.75 USD for its 5 year Chinggis bond which was issued at 1000 USD and 10037.5 yuan in exchange for its yuan denominated Dim Sum bond.

A road show of the new bonds to the buyers started Tuesday from New-York to Hong Kong via Boston, London, Singapore. As reported by Reuters, Credit Suisse, Deutsche Bank as well as JP Morgan are working as major underwriters of the upcoming bonds.

Global credit rating agencies Fitch Ratings and Standard and Poor's, have given the government's forthcoming long-term USD



BBM®

bond an expected "B-" rating as "stable". The agencies say that despite the stabilization of fiscal deficit, the state's income is still low, while expenditure remains high. Eight months ago, Mongolia

successfully raised financing from international market for repayment of Euro bond. But now financial source for the repayments of the two bonds are still uncertain. Amount of funding and interest

rate will be estimated based on investors' proposals and their demands. The officials are trying to raise about 660 million USD, the total financing needed for the two bonds said a source at the Ministry

of Finance.


According to Manduul.N, chief of the Financial Policy of the Ministry of Finance, interviewed by Bloomberg TV, the interest rates of the upcoming bonds may be less than 8.75 percent.

Mongolia's economic situation has improved since Mongolia sold "Khuraldai" bond at the beginning of this year. GDP growth which had fallen to one percent at end of the 2016, increased to 5.3 percent in the first half of this year.


Moreover, it's clear that almost 3.5 billion USD cash will flow from international donors in the next 2-3 years including 1.2 billion USD from ADB. In the first half of 2017, amount of foreign direct investment turned into positive region. In terms of politics, there are positive trends including the confirmation of the new PM and his cabinet consisting 100% of MPs. [ZGM]

## Main economic indicators


### Housing Price Index (a year to date)



### Fiscal balance 2017 (nine months to date)



### Inflation Rate (a year to date)



## COOPERATION

### IMF delegation arrives in Mongolia

**Gerel Zorig**  
ZGM

The IMF's team arrived in Mongolia this week to work with Bank of Mongolia to resume negotiation for the first and the second review of the EFF program.

The President of Bank of Mongolia Bayartsaikhan Nadmid met with Managing Director of the IMF Christine Lagarde during the Annual Meetings of the World Bank Group and the International Monetary Fund in Washington last week. The Governor of Bank of Mongolia pointed out about Mongolia's continuous contribution to implement-

ing the the program.

"Recently, Prime Minister has also sent a letter to the Managing Director of IMF and stated that the incoming Government remains committed to the program" said Geoff Gottlieb, a newly appointed chief of the IMF's Mission chief for Mongolia.

According to the source of ZGM in Washington D.C, Geoff Gottlieb may discuss on the third tranche of the EFF and granting the second and the third tranche to Mongolia in December.

"I'll be leading a team back to Ulaanbaatar to resume negotiation for the first and the second review of the program. The program was



put on hold as a result of the changing Government, but I look forward to having constructive dialogue going forward" said Geoff Gottlieb in Washington. [ZGM]

## ZGM: GUEST

### Ahmet Yazal: Turkish Airline is the second "leg" of our trade

**Tselmeg Zorig**  
@tselmegZGM

*Mr. Ahmet Yazal, Ambassador of the Republic of Turkey to Mongolia, spoke with The official Gazette (ZGM) about the possibilities of broadening economic cooperation and increasing trading volume between the two countries.*

**-The current level of cooperation between Turkey and Mongolia doesn't fully complement its potential. What are ways to promote collaboration between the two countries?**

-Yes, there is a big potential for changing that. If you check the investment numbers from your agencies, total trade and direct investment would be just 13 million US dollars. So we would like to convince Turkish companies that Mongolia is not just Mongolian market. By investing here, it's also possible to reach other regional countries and export products, even to European Union.

**-What about growing trade volumes?**

-There is a great potential of doing business here, like for leather industry. We don't have to take leather from Mongolia to Turkey, but can bring the companies here. And do what they want to do with all the skins here and then export them as products of Mongolia. So that is one thing. There are lots of other similar options for Turkish companies in Mongolia. Firstly, we need to facilitate travel and movement of goods. Also, we have to inform Turkish businesses about the variety of possibilities.

**-What is the biggest challenge for Turkish investors and businessmen doing business in Mongolia?**

-The problem for Turkish investors in Mongolia is that they don't know the opportunities that Mongolian market presents. That is the main obstacle. The next one is the difficulty of freighting in Mongolia.



S.Batsaikhan / ZGM®

For person and businessman but also for their goods. They can export a lot of stuff by air cargo but they can't do it in Mongolia. They can bring a lot of businessmen to see it for themselves and establish contacts but it is too expensive for them to come here and they don't know who to talk to and what to talk. So these are the things we are working on.

**-Turkish Airline's net profit rose almost 12 times between 2003 and 2015. What is the secret of the success? What kind of policy does the state implement in air transportation?**

-What I can tell you is, it used to be state owned and was privatized. Some shares are still owned by the Government. But of course, Turkish Airlines have very good relations with the Government. What we do is, our system of economic growth is based on international trade and exports. And we want to make sure that we have good and increasing trade links with every country around the world. That's why we are sometimes asking Turkish Airlines to fly to destinations, normally they wouldn't fly as a commercial company. And Mongolia is one of them. We are asking Turkish Airlines to look at the picture globally, not look at every destination. That is the first thing. Second thing is Turkish Airlines is willing to fly to more destinations than other airlines.

Some other airlines in the world are more focusing on regions. We

are trying to reach the whole world and for that we have a huge advantage, Istanbul airport. Its location is perfect. It is right in the middle of the world. To make that advantage even bigger, we are building a new airport, which will be the biggest in the world.


**-I heard that Turkish Airline is a tool of the two "legs" policy. Tell me a little bit about it?**

-It's not officially declared as a policy. We have a system to use for promoting trade links with other countries. Once we were starting to open in Central Asia, Africa, Latin America. We realized that with the countries we have lots of agreement, but trade turnover was not increasing. Then we checked which country is easier to increase trade relations. We realized that if we have Turkish Embassy or Council in that place, and if Turkish Airlines is flying directly to that country, then it is easier for Turkish businessmen, not the bigger ones, the small and medium-sized Turkish businessmen to enter that country.

For Mongolia, we have an Embassy so they can come and ask for help. We have Turkish Airlines flights that is the second leg, but it is half because it stops in Bishkek. So, it is too expensive, too long and they can't bring cargo. If they have an agreement to sell goods to Mongolia, the only way they can bring it is either by truck from Russia or by ship through China. And it takes too long. [ZGM]

## ZGM INFOGRAPHICS

### MONTHLY EXPENSES FOR A POOR MONGOLIAN 2016



Mongolia's poverty level is estimated at 29.6%. In UB 24.8% of the population lives below the national poverty line.

# Лавлах

## ХИЛИЙН ЧАНАДАД АНУ-д халдлага болж Монголын иргэн өртжээ

Б.Сэлэнгэ  
ЗГМ

АНУ-ын Мэрилэнд мужид амьдардаг Монгол Улсын иргэн зэвсэгт халдлагад өртөн нас баржээ. Тус мужийн нэгэн байгууллагын ажилчин өнгөрсөн лхагва гарагийн өглөө ажлын байран дээрээ гал нээж, хамтран ажиллагсдынхаа гурвыг хөнөөсний нэг нь Монгол Улсын иргэн 53 настай Т.Баярсайхан байжээ.

The New York Times сонины мэдээлснээр гэмт хэргэгч Т.Баярсайхан нарын гурван хөнийг хөнөөснийхөө дараа Делавэр лүү очиж, машины наймаа хийдэг байсан хуучин ажлынхаа хүмүүсийг буудсан аж.

Энэ талаар Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас мэдэгдэл гаргасан бөгөөд үүнд талийгаачийн талаар тодорхой мэдээлэл өгөх боломжгүй талаар дурдсан байв. Тус мэдээнд "Гадаад харилцааны яамнаас холбогдох арга хэмжээ авч, ар гэртэй нь холбоо тогтоосон болно. Нас барсан иргэний ар гэрийн хүсэлтийг хүндэтгэн дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Гадаад харилцааны яам Вашингтон дахь ЭСЯ-аараа дамжуулан талийгаачийн ар гэрт шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлэх болно" гэжээ. Хэрэгтэн 37 настай Радий Лабеб Принц гэх эрийг хэрэг үйлдсэнээс 10 цагийн дараа баривчилсан байна. [ЗГМ]

## БАЙГАЛЬ ОРЧИН Туул голын бохирдлыг судалж байна

Туул голын сав газрын экологийн төлөв байдлын үнэлгээ" төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сан, Туул голын сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлж эхэллээ.

Нэг жил зургаан сарын турш үргэлжлэх уг судалгаагаар Туул голын төлөв байдлыг үнэлж, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хууль эрх зүйн орчинд ямар үнэлгээтэй байгаа талаарх мэдээллийг боловсруулах юм. [ЗГМ]

## ЭРҮҮЛ МЭНД Даатгалаараа шинжилгээнд үнэгүй хамрагдаарай

Даатгуулагчийг эрүүл мэндийн улмаас үүсч болох санхүүгийн эрсдэлээ хамгаалах зорилгоор 40, 45, 50, 55, 60, 65 насны бүх даатгуулагчийг 2017 онд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулахаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл шийдвэрлэжээ. Энэ талаар өчигдөр мэдээлэл хийсэн юм.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга С.Наранцэцэг "Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгооны тухайд 50 мянган төгрөгийн гурван төрлийн багц шинжилгээнээс нэг багцыг даатгуулагч өөрөө сонгон оношилгоо, шинжилгээнд үнэгүй хамрагдана. Нэгдүгээр багц нь даатгуулагчийн элэг, ходоод, бөөрний өвчлөл, чихрийн шижин, судасны хатуурал, ходоодны үрэвслийн багц юм. Хоёрдугаар багц нь нэгдүгээр багцын шинжилгээн дээр нэмэгдээд үе мөч булчингийн өвчлөл орно. Гуравдугаар багц нь элэг, ходоод, бөөрний өвчлөл, чихрийн шижин, судасны хатуурлаас гадна ходоод, умайн хүзүү, түрүү булчирхайн хавдрыг илрүүлдэг чиглэгдсэн байгаа" гэв [ЗГМ]

### ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
<b>08.00</b>	09:00 "Миний жаахан нар" Хятадын уран сайхны кино 17, 18 дугаар анги	09:00 "Амралтын цэнэг" хөтөлбөр	08:05 "Монголчууд XX зууны эхэнд" нэвтрүүлэг	09:30 "Тог тог тог" (season-5) 24 дүгээр хэсэг
<b>12.00</b>	11:00 "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр (шууд)	11:00 "Блумберг форум" нэвтрүүлэг	12:10 "Анна каренина" ОАК 7 дугаар анги	12:30 "Эрүүл мэндийн өмгөөлөл" ОАК 14 дүгээр анги
<b>14.00</b>	14:00 "Цэлмэг" өдрийн хөтөлбөр (шууд)	14:30 "Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг	14:10 "Аяаг таа" асуулт, хариултын шоу нэвтрүүлэг	15:30 "Дээдсийн хүрээлэн" СОАК 5 дугаар анги
<b>18.00</b>	17:30 ННХ-Жайка үзүүлж байна: "Нунтаг цас"	17:00 "Амралтын цэнэг" хөтөлбөр	17:05 "Кунг Фу Панда" хүүхэдзүйн кино 23, 24 дүгээр анги	18:30 "Наашаа Цаашаа" хөтөлбөр
<b>20.00</b>	19:40 Шуранхайн нууцад нэвтрэхүй: "Амбан цэцэн хааны хүлэг"	20:00 Чарли Роузын ярилцлага	20:40 "Дэлхийн атлас" танин мэдэхүйн нэвтрүүлэг	21:00 "Миний дүрсгүй гүнж" СОАК 10 дугаар анги
<b>22.00</b>	21:05 "Баасан гараг" цэнгээнт нэвтрүүлэг (шууд)	22:00 "Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг	21:50 Дэлхийн санхүүгийн түүхүүд	00:00 "Декстер" ОАК (season-7) 8 дугаар анги


### ОНЦЛОХ ҮЗВЭР

## Тамгагүй төр дахин тайзнаа



Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Б.Лхагвасүрэнгийн зохиол "Тамгагүй төр" жүжиг Улсын драмын эрдмийн театрт өнөөдрөөс эхлэн тоглогдоно. Хаан Арчугт их хатан Цэцэр, бага хатан Гүргэл нар нэг өдөр хоёр нуган үр төрүүлэн өгнө. Гэвч үр заяах битгий хэл үнэрийг нь мартсан эх хатныхаа хүүг өөрийн хүү биш тул бага хатан Гүргэлээс төрсөн хүүгээ өлгийтэйд нь хаанд өргөмжлөхөөр зарлиг буулгана. Хааны итгэлт шадар Эгээрэг энэ зарлигийг нь эсэргүүцэж яаж ч чадахгүй буцахдаа их хатан Цэцэрийн хэвлийгээс төрсөн өөрийн нууц хүүхдээ хэрхэн хааны сэнтийд суулган жаргах тухайгаа сэтгэн байна. Их хатан Цэцэр өөрөөс төрсөн нялх үрээ солихыг үл хүсэвч ёсоор болгож, бага хатны хүүг өөрийн хүүтэй солино. Үйл явдал цаашид хэрхэн өрнөхийг өнөөдрөөс эхлэх Тамгагүй төр жүжгээс та үзээрэй. Тасалбарын үнэ суудлаасаа хамааран 10-25 мянган төгрөг байх аж. [ЗГМ]

### ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



#### БОСООГООР:

- Эмх
- Арьсан дахь толбо, тэмдэг
- Зуны эхэн сарын нэр
- Говьд ургадаг ургамал
- Толгойн доод хэсэг
- Аймгийн нэр
- Тун гэсэн тодотгол үг
- Х-ТҮЦ хамтлагийн жүжигчин, МУГЖ
- Бугын төл
- Хүн хар гөрөөс
- Аварга загас
- Жимс



#### ХӨНДЛӨНГӨӨР:

- Хувцас
- Түшиг
- Их хааны бага насны нэр
- Италийн нийслэл хот дахь хот улс
- Адуу илжигний эрлийз
- Майхан

Өмнөх дугаарын хариу / 10.19




### ЗГМ: СҮДОКУ




(Өмнөх дугаарын хариу)

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР



### ЗГМ: КОМИКС



**[ЗГМ СОНИН]**

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

"ZGM-FINANCIAL TIMES" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

**99903581, 70103131**

УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТой САНАЛ ХҮСЭЛТЭЭ

**INFO@ZASAG.CO**

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

### ҮЗВЭР

#### МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

Нэрт зураач Надя Рушевагийн сор бүтээлээс бүрдсэн "Найдан" үзэсгэлэнг энэ сарын 30 хүртэл олон нийтэд үнэ төлбөргүй үзүүлж байна. Түүний ертөнцийн илрэл болсон 10 мянган зургаас дээжлэн 80 гаруйг нь дэлгэжээ.

#### СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨ

Морин хуурын чуулгын 25 жилийн ойн баярын тоглолт маргааш 15.00 цагт болно. Тус тоглолтын ерөнхий найруулагчаар хөгжмийн зохиолч Н.Жанцанноров ажиллана. Хөгжмийн зохиолч Ш.Өлзийбаярын "Морин хуур симфони найрал хөгжмийн хоёрдугаар концерт", Н.Жанцанноровын "Ятгын хоёрдугаар концерт" зэрэг сүүлийн таван жилд хийсэн сор бүтээлээс эгшиглүүлнэ.

#### "ӨРГӨӨ" КИНО ТЕАТР

Бүтэлгүй хайр дурлалаасаа болж шаналсан найзынхаа сэтгэлийг засах гэж гурван найз бүсгүй хөдөөгийн замд жолоо залснаар бүх адал явдал эхэлнэ. Гурван бүсгүйн хайр дурлалын төлөөх тэмцлийг харуулах "U Film" кино компанийн бүтээл "Single ladies 3" романтик инээдмийн кино лхагва гарагаас үзэгчдийн хүртээл болж эхлээд.

#### HARD ROCK CAFE

"Аадар" хамтлагийн анхны цомгийн баяр маргааш 20.00 цагт болно. Энэ үдэш "Аадар"-ынхан "Дүрлэлэн ас", "Хачин дурлал", "Би чамд хайртай" зэрэг сонгогчдод хүрсэн дуунаасаа гадна цоо шинэ бүтээлээ толилуулана.

### ЗУРХАЙ



#### Билгийн тооллын 1

Намрын дунд шарагчин нохой сарын зургаан цагаан мэнгээтэй цагаан луу өдөр. **Үс засуулбал:** Нас ахар болно **Барилдлага:** 07.23-18.02 **Барилдлага:** Үл тохирох **Шүтэн барилдлага:** Сансар **Суудал:** Гал

#### Аргын тооллын аравдугаар сарын 20, Сугар гараг. Билгийн тооллын 1, Салхины эх одтой, цагаан луу өдөр.

Өдрийн наран 07.23 цагт мандаж, 18.02 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ саям нөлөөтэй тул элдэв үйлд хөрөнгө хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхтох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Хяруу унах улирал 13.02 цагт эхэлнэ. Үс шинээр үргэлжлэх буюу засуулахад тохиромжгүй.

#### ГАЛТ ЭЭРЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Эрхүү	21:10	02:40
Эрхүү-УБ	15:35	06:20
УБ-Замын-Үүд	20:00	07:50
Замын-Үүд-УБ	21:35	09:55
УБ-Эрдэнэт	20:30	07:45
Эрдэнэт-УБ	19:10	05:48
УБ-Сүхбаатар	10:55	19:52
Сүхбаатар-УБ	06:30	15:35
Сайншанд-УБ	20:25	07:01
УБ-Сайншанд	09:15	19:15

#### НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-Бусан	06:05	10:35
Бусан-УБ	11:30	14:30
УБ-Хонконг	06:25	10:55
Хонконг-УБ	12:05	16:45
УБ-Сөүл	08:45	12:50
Сөүл-УБ	14:20	16:50
УБ-Ханбумбат	08:40	09:50
Ханбумбат-УБ	22:00	23:05



## Катар баялгийн сангаасаа 20 тэрбумыг татлаа

Хэрэг явдал Персийн буланд олон жил үзэгдээгүй хямрал үүсгэсэн билээ. > 10

## Оросын телевизийн нэвтрүүлэгч В.Путинтэй өрсөлдөнө

Собчакийг шүүмжилсний дээр "Шоу бизнесийн ажилдаа дэм болгож байгаа юм" гэжээ. > 10

## АНУ 1965 онд Индонезийн аллагыг дэмжсэн нь нотлогдов

Дэглэм доторх засгийн эрхийн төлөө тэмцлээс үүдэлтэй талаар мэдээлэл авсан байжээ. > 10



BVM©

# Ши Жиньпиний түүхэн амбиц

Том Митчелл, Чарльз Кловвер

Хятад шиг аварга, эдийн засгийн жин ихтэй орны удирдагч гэхэд Ши Жиньпин "улс орны нөхцөл байдлын" талаар жил тутмын илтгэл тавьдаггүй уламжлалтай. Ийм илтгэлийг БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Кэчян жил бүрийн гуравдугаар сард парламентын чуулганд "ажлын тайлан" нэрээр тавьдаг. Гэтэл БНХАУ-ын дарга Ши Жиньпин таван жилд ганц удаа хуралддаг ХКН-ын их хуралд лхавга гарагт эхлэхэд үг хэлсэн нь түүнийг 2012 оны 11-р сард төрийн эрхэнд гарсан цагаас хойш анх удаа тохиолдож буй ховор үзэгдэл боллоо.

Тэрбээр хурлын ихэнх хугацаа буюу гурван цаг хагасын турш үг хэлсэн нь их хуралд оролцогч 2300 төлөөлөгчийг гайхшруулав. Суудалд бусдын тусалцаатай босож, сууж байсан, нас сүүдэр 91-тэй хуучин дарга Жян Зөмин илтгэлийн үеэр бугуйн цаг руугаа байн хяламхийсээр.

"1984-ын Их ах санаанд ороод байх юм" хэмээн Жорж Орвеллын баргар романд гардаг эцэс төгсгөлгүй улс төрийн сурталчилгааг дурдан байж нэг нь постложээ. Таван жилийн өмнө, тухайн үед БНХАУ-ын дарга байсан Ху Жиньтао намын их хуралд харьцангуй товч буюу 90 минут үг хэлсэн.

Харин ноён Ши өмнөх хоёр дарга Ху, Жян нараас илүү амбицтай. Дэн Сяопин өөрөө биечлэн дэмжиж байсан учраас

Ху, Жян нар их удирдагчтай нягт холбоотой хүмүүс байв. Тэгвэл ноён Ши ч өөрийнхөө засаглалын үеийг дэлхийн хоёр дахь гол эдийн засгийн хүчирхэг шинэ эриний эхлэл хэмээн ойлгуулах төлөвлөгөөтэй. "Дорно этгээдэд Хятад улс эрс шийдмэг, цэх шулуун өндийж байна" хэмээн ноён Ши тунхаглав. Энэ үг ХКН-ын хувьсгалч баатар Мао Зэдун 1949 оны есдүгээр сард "Хүн төрөлхтний дөрөвний нэг - Хятадын ард түмэн хөл дээрээ бослоо" хэмэсэн алдарт үгийн цуурай аятай сонсогдсон юм.

Тунхгийг намын төлөөлөгч нар хожмын орон нутгийн хуралдаанууд дээр тоть аятай давтагчаалаа. "Манай нам Ши Жиньпиний цөм удирдлага дор шинэ эрин үед шилжлээ" хэмээн Шааньши мужийн намын босс Лоу Чиньжянь зарлав.

"Анхааралд өртсөөр ирсэн ч шийдвэрлэхгүй байсан түвэгтэй олон асуудлыг бид шийдвэрлэж чадлаа" хэмээн ноён Ши өгүүлсэн нь 2012 он хүртэл үргэлжилсэн Хугийн 10 жилийн дурдаж буй бололтой. Хятадын албаны олон хүн "алдагдсан 10 жил" хэмээн тодорхойлдог энэ үед авлига гаарчээ. Ийм ч учраас дээрх хүмүүс ноён Шигийн "Улс үндэстнийг дахин залуужуулах хятад мөрөөдлийг хэрэгжүүлэх" санаачилгыг уриалгахан хүлээн авсан юм.

"Энэ их хурал нь улс төрд хяналтаа тогтоох хурал" хэмээн

Хятадын бодлогын эксперт, Бээжинд амьдардаг шинжээч Жюд Бланшет тайлбарлав.

ХКН-ын XIX их хурлын лхагва гарагийн нээлтний хуралдаан хэрэг дээрээ амин чухал нууц зөвлөгөөний өмнөх ариутгах ёслол юм. Энэхүү их хурал аравдугаар сарын 24-нд ХКН-ын хамгийн хүчирхэг байгууллага болох улс төрийн товчооны байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинээр томилох ёстой.

Шинэ удирдлагын бүрэлдэхүүн нь БНХАУ-ын дарга улс төрийн далд тохиролцооны эцэст эрх мэдлээ бэхжүүлж чадав уу, тогтсон 10 жилээс илүү хугацаагаар албан тушаалаа хаших боломж бүрдүүлэв үү гэдгийг харуулж өгнө. "Ши хоёр дахь багаа бүрдүүлэхэд бүрэн эрх эдэлж чадаагүй. Эдлэх ёстой эрхээ бол мэдээж эдэлнэ" хэмээн Хятадын бодлого тодорхойлогч нарын зөвлөх нэгэн тайлбарлаж байлаа.

Ши Жиньпин ХКН-ын дүрэмд "Шигийн онол" гэсэн нэр томьёо оруулж болзошгүй тухай таамаг бий. Урьд нь энэхүү хүндтэй эрхийг ердөө Мао, Дэн хоёр эдэлсэн түүхтэй. "Ши намын дүрэмд нэрээ оруулчих юм бол Байнгын хороонд хэн хэн байх нь чухал биш. Учир нь ийм хүнтэй сөргөлдөх тун аюултай" хэмээн Вашингтон дахь Стратеги, олон улсын судалгааны төвийн Кристофер Жонсон тайлбарлав.

Намаас 2013 онд шинэчлэлийн

хөтөлбөр дэвшүүлж байх үеийнхтэй адилаар, ноён Ши лхагва гарагт хэлсэн үгэндээ зах зээлийн механизмыг чухалчилж, төрийн өмчийн хүчирхэг үйлдвэр компани байх ёстойг цохон дурдлаа. Мөн гадаадын компаниудад илүү чөлөөтэй ажиллах боломж олгож, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахаар амлав.

Дөрвөн жилийн өмнө амласан эдийн засаг, санхүүгийн олон шинэчлэлээс нэлээдийг нь Шигийн засаг захиргаа хэрэгжүүлж чадаагүй. Оронд нь ХКН-ыг "улс орны гол тулгуур" хэмээн байн байн мэдэгдсэн нь улс төрийн эрх мэдлийг эдийн засгаас дээгүүр тавьж буйн илрэл болсон юм.

"Энэ их хурлаас айхавтар өөрчлөлт гарахгүй болов уу. Тодорхой бүлгийнхний эсэргүүцлээс болоод 2013 онд дэвшүүлсэн шинэчлэлийн хөтөлбөрийн ихэнх нь хэрэгжилгүй өнгөрсөн" хэмээн Харвардын их сургуулийн профессор Тони Сэйч өгүүлэв. Гэхдээ шинэ удирдлагыг томилохоос намын дүрэмд өөрчлөлт оруулах хүртэлх олон асуудлыг шийдвэрлэж, шинэчлэл ч зохих хэмжээгээр үргэлжилнэ хэмээн профессор үзэж байна. "Аж ч нарийн бэлтгэлээ гэсэн, олон юмыг хамгийн сүүлчийн минутад шийддэг" хэмээн тэрбээр тайлбарласан юм.

FT

# Цахиурын хөндий болох Японы өрсөлдөөн

Питер Уэлс


Орчин цагийн эдийн засаг бүр Цахиурын хөндийн өөрийн гэсэн хувилбартай болох мөрөөдөлтэй. Япон орон ч ийм хөндий илрүүлэх үү, байгуулах уу гэсэн асуудлыг шийдвэрлэх гэж байна.

Наран улс шинийг санаачлагч - инноватор гэдэг нь эргэлзээгүй. Гэхдээ л цагтаа хүчирхэг байсан Японы цахим хэрэгслийн компаниудад хүртэл дижитал эрин үед шуурхай зохицох нь амаргүй даваа.

"Цахиурын хөндийн эрч хүчийг Японд аваачмаар байгаа" - гаа ерөнхий сайд Шинзо Абэ 2015 онд тус технологийн хөндийд зочлох үеэрээ мэдэгдсэн.

Технологийн зангилаа цэгийн үүрэгтэй газар Японд олон. Гэхдээ эдгээр зангилааны чухам аль нь өөрөө хөгжин, технологийн старт-апууд цэцэглэдэг Цахиурын хөндий болоход илүү тохирох талаар маргаан ид өрнөж байна.

Кюшюу арлын баруун өмнөд оршдог, 1.5 сая хүнтэй Фүкүока хот энэхүү алдрын төлөө өрсөлдөгчийн нэг. Тус хотын захирагчийн албан тушаалыг 2010 оноос хойш хашиж буй Соичиро Такашима старт-ап хөгжүүлэх бодлогод тулгуурладаг нь ийнхүү өрсөлдөх суурийг тавьжээ. Ноён Такашима нь Фүкүокага Японы эдийн засгийн тусгай бүсийн стартууд болгоход гол үүрэг гүйцэтгэж, Японд "старт-ап виз"-ийг анх нэвтрүүлсэн хүн. Уг визийн дагуу гадаадын бизнес эрхлэгчдэд Японд бизнес эхлэх нөхцөлийг хөнгөвчилж, старт-ап компанийнх нь хувьд бага татвар авдаг.



BVM©

Инженерчлэл, мэдээллийн технологи, анагаах ухаан хүчтэй хөгжсөн Фүкүокад оффисын түрээс хямд, их сургуулийн сүлжээ сайн хөгжсөн нь гадаадынхныг татах хүчин зүйл. Хүчин чармайлт ч зүгээр өнгөрсөнгүй. Тус хотын захиргаанаас гаргасан статистикийг үзвэл, хотын даргын чармайлтын ачаар 2016 он хүртэлх дөрвөн жилд Фүкүокад шинээр үүссэн 260 старт-ап компанид 11638 хүн ажиллаж байна.

Фүкүокад салбараа шинээр нээж буй том компаниудын дотор ухаалаг утасны чат аппликэйшн хөгжүүлэгч Line, Японы гэйм тоглоомын Gumi багтаж байгаа. Гэхдээ л эдгээр компани нь технологи, старт-апын ертөнцийн хүнд жингийн тоглогчдын зиндаа биш.

Ийм зиндаа Киото хотод бий. Японы эртний нийслэл, шилдэг зэрэглэлийн инженерчлэл, технологи, биотехнологийн компаниудаараа алдартай, эрдмийн уурхай гэгддэг Киото хот ч Японы Цахиурын хөндий болох хүсэлтэй. Тус хотын Murata Manufacturing, Rohm, Kyocera компани Apple-ийн ханган нийлүүлэгч төдийгүй үйлдвэрлэлийн төрөл бүрийн салбар, зах зээлд эзэлдэг байр суурь нь дэлхийн хэмжээнд ярих түвшинийх.

Энэ хот бол видео тоглоомын

үйлдвэрлэлийн агуу инноватор Nintendo-гийн өлгий нутаг юм.

Киотогийн компаниудын үйл ажиллагаа нь үлгэр жишээ авах гээд байгаа АНУ-ын загвараас ялгаатай. АНУ-ын Цахиурын хөндийд Facebook, Google, Amazon, Uber, Airbnb зэрэг интернет, программ хангамжид чиглэсэн компани ноёрхдог бол Киотод техник хангамж үйлдвэрлэгч нар нь илүү алдартай.

Япончуудын техник хангамжийн инновац Токиогоос зүүн хойш цаг орчим давхиад хүрдэг шинжээ ухаан, технологийн парк Tsukuba Science City-д тод харагдана.

Анх 1960-аад оны үед сууриа тавьсан Цүкүба нь улсын түвшний 60 гаруй судалгааны хүрээлэнгийн өлгий, Японы судалгааны төсвийн талыг хэрэглэгч юм. Тус хот автомат жолоодлоготой машины туршилтын зам хэдийн байгуулсан. Энд байрладаг старт-ап Cyberdune компани хотынхоо эмнэлэг, асрамжийн газруудад удахгүй хийж дуусгах их ажлын эцэст Цүкүба нь "роботын хот" болж хувирна.

Токиогийн Шибүяа дүүрэг ч Японы Цахиурын хөндий гэсэн алдрын төлөө, гэхдээ бүр хоёр дахь удаагаа өрсөлдөж байна. Тус дүүрэг нь "Хачикогийн бужигнаан" гэгддэг дэлхийд явган зорчигчийн хамгийн ачаалалтай уулзвараараа алдартай. Dotcom boom буюу интернет хэрэглээний гэнэтийн тэсрэлт болсон 1990-ээд оны эцэс, 2000-аад оны эхэн үед Шибүяад Японы интернет старт-апууд төвлөрч, компьютерийн bit хэмээх нэр томьёо орсон "Бит хөндий"

# YouTube-ийн хиймэл оюун экстремист видео бичлэгийг ялгаж байна

"Ийм контентыг шуурхай илрүүлж, сүлжээнээс авч хаяхад туслах ангилан ялгагчийг дадлагажуулж бэлтгэхийн тулд машин суралцахуйн дэвшилтэт судалгааг түлхүү хөгжүүлэх хэрэгтэй" хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

Хүчирхийллийн сурталчилгаатай тэмцэхэд илүү ихийг хийх ёстой хэмээн АНУ, Европын улсуудын Засгийн газраас технологийн аваргуудыг шүүмжлэх болсонтой уялдан экстремизмийг илрүүлэх технологи хөгжүүлэх дарамт эрс ихэссэн юм.

Twitter энэ оны эхний хагаст 300 мянга орчим террорист аккаунт устгаснаа өнгөрсөн сард мэдэгдлээ. Устгалыг үндсэндээ машин суралцахуйн алгоритмд түшиглэж явуулжээ. Экстремист аккаунт илрүүлж, устгах хэмжээг ихэсгэх үүднээс автоматжуулсан технологид хөрөнгө оруулаад байгаагаа Facebook зургадугаар сард тайлбарласан.



BVM©

YouTube-ийн статистикаас үзвэл, есдүгээр сард устгасан экстремист видео бичлэгийн 83 хувийг математик алгоритмын тусламжтай илрүүлсэн нь өмнөх сарын үзүүлэлтээс найман хувиар их байна. Машин суралцахуй ашигладаг болсноос хойш тэмдэглэгээ тавьдаг видео

бичлэгийн нийт тоо ч эрс өссөн. Гэхдээ хиймэл оюун ухаан тухайн бичлэгийг устгахаас өмнө бодит хүн бүгдийг нэг бүрчлэн шалгаж байгааг YouTube-ийн хэвлэлийн төлөөлөгч мэдэгдэв.

YouTube ашиглаж буй алгоритм нь сэжигтэй гэж үзсэн контентынхоо тег-шошго, гарчиг,

зураг дурс, өнгөний илэрц зэрэг янз бүр шинж тэмдгийг шалгаж үзэхэд тулгуурладаг. Хиймэл оюуны ялгасан контентыг дараа нь хүн шалгаж тухайн материал хүчирхийллийг сурталчилж уу, зүгээр баримт болгож уу гэдгийг давхар тодорхойлдог юм.

FT

FT

## Оросын телевизийн нэвтрүүлэгч В.Путинтэй өрсөлдөнө



Макс Седдон

Нэвтрүүлэгч, нийгмийн сүлжээний идэвхтэн Ксения Собчак ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд Владимир Путинтэй өрсөлдөхөөр нэрээ дэвшүүлнэ хэмээн зарласан. Энэ нь сөрөг хүчнийг бутаргах санаа агуулсан илт хуурмаг алхам шиг харгдаж байна. Тэрбээр Ведомости сонины лхагва гарагийн дугаарт нийтлүүлсэн захидалдаа түүний нэрийг сөрөг хүчин бүгдийн эсрэг санал өгөхөд ашиглахыг хүсэж байна гэжээ. Телевизээр шоу хөтөлж нэрд гарсан энэ эмэгтэй “Та бодлоо илэрхийлэхийг хүссэн боловч таны нэр дэвшигч сонгуульд өрсөлдөөгүй бол яах вэ? Собчакийг дугуйл. Түүнийг Ерөнхийлөгч болгоно гэсэн үг биш. Зүгээр л хангалттай боллоо гэсэн санаагаа хууль ёсны дагуу, энхийн аргаар илэрхийлж буй хэрэг” гэж бичсэн байна.

Төрийн эрхийг 18 жил атгасан ноён Путин ирэх гуравдугаар сард болох сонгуульд нэр дэвших эсэхээ оны эцсээр зарлаж магадгүй. Кремль сонгуульд санал өгөгчдийн тоо буурч байгааг сэргээхийн тулд сөрөг хүчнээс өөрийн хяналтад байдаг иймэрхүү будилаан үүсгэгчийн нэрийг дэвшүүлэх арга хэрэглэдэг. Оросын сөрөг хүчний нэр хүндтэй төлөөлөгч Алексей Навальный хэлэхдээ Путин эсрэг хүчнийг хагалан бутаргахын тулд нэрээ дэвшүүлэх гэж байна хэмээн хатагтай Собчакийг шүүмжилсэн юм.

Навальны залилангийн хэрэгт хутгалдаж, нэр дэвших эрхээ хасуулсан боловч өөрөө үүнийг улс төрийн зорилготой явуулга хэмээн тайлбарлажээ. Тэрбээр ямар ч гэсэн сурталчлалга эхлүүлж, 600000 хүний гарын үсэг цуглуулсан бөгөөд орон даяар сонгуулийн штабаа байгуулаад байна. Таван жилийн өмнө Путинг дахин Ерөнхийлөгч болохыг эсэргүүцсэн хөдөлгөөний үеэр Собчак сөрөг хүчинд нэгдсэн боловч Кремль түүнийг болом-

жийн нэр дэвшигч гэж үзэж буй. 35 настай энэ эмэгтэйн эцэг Анатолий Собчак асан 1990-ээд онд Петербург хотын захирагч байсан агаад Путиныг улс төрд хөтөлсөн хүн юм.

Оросын Ерөнхийлөгч түүний загалмайлсан эцэг гэх цуу яриаг Собчак өөрөө эрс няцаадаг. Тэрбээр нэр дэвшихээ зарлахын өмнөхөн наанаа бол эцгийнхээ тухай ярилцлага авах нэрийдлээр ноён Путинтэй уулзсан. Түүний ярьснаар Путин “Хүн бүр сонголт хийх эрхтэй гэж хэлсэн” аж. Нэг үеийнхэн солигдох үйл явц Собчакийн сонголтоор илэрч байж магадгүй юм. Кремлийн улс төрийн технологич асан Алексей Чеснаков “Ксения бидний аавууд хийж чадаагүй зүйлийг хүүхдүүд нь чадна гэсэн үзэл санаа дэвшүүлэхийг оролдож байна. Би бол аавын охин гэж тэр зүгээр ч нэг хэлээгүй. Гэвч түүнд сөрөг зүйл дэндүү олон бий. Тэр олон нийтийг татаж чадахгүй байх” гэжээ.

Оны эхээр Навальный орон даяар эсэргүүцэл зохион байгуулсан нь Кремлийг тугшээсэн байж магадгүй. Тэрбээр орон нутгийн жижиг хогуудаас кампания эхэлж, олон түмнийг татсан боловч энэ сард жагсаал цуглааны журмыг зөрчсөн хэргээр 20 хоног хоригдох ял авсан. Навальный либералуудыг олны инээдэм болгоё гэх сэдлээр тоглолт хийж байна хэмээн Собчакийг шүүмжилсний дээр “Шоу бизнесийн ажилдаа дэм болгож байгаа юм” гэжээ. ОХУ-ын Сонгуулийн комиссын төлөөлөгч ноён Навальный хориг 2028 онд дууссаны дараа нэрээ дэвшүүлж болно гэж мэдэгдсэн. Харин Собчак ноён Навальный нэр дэвшихийг дэмжиж буйгаа илэрхийлээд ийм тохиолдолд нэрээ татна гэсэн байна. Тэрбээр “Би таны нэр дэвшигч биш байж болох юм. Гэхдээ би энэ сонгуульд оролцож байгаа сонгогчдын хувь сайн хэрэг бөгөөд Оросын улс төрийн тогтолцоонд хэрэгтэй” хэмээн бич-



## Катар баялгийн сангаасаа 20 тэрбумыг татлаа

Эндрю Энгланд, Саймон Керр

Хөршүүд нь хориг тавьсан хүнд цаг үед Катарын Сангийн сайд Али Шарид Аль-Эмади “Хил залгаа зарим улстай асуудал үүсээ гээд бид бизнес, стратегиа зогсоохгүй” гэж мэдэгдэв. Катарын төрийн мэдлийн баялгийн сангаас хоригийг сөрөхийн тулд 20 тэрбум ам.долларыг зарцуулахаар татан ирүүлжээ. Энэ мөнгийг банкны төлбөрийн чадварыг дэмжих болон эдийн засгийн “жийрэг” болгон ашиглана гэж Сангийн сайд мэдэгдлээ. Саудын Араб, Эмират, Бахрейн, Египет улсууд Катартай зургадугаар сард дипломат харилцаагаа тасалж, тээврийн шугамаа хаасны дараа эндээс 30 тэрбум ам.доллар гадагш урсан юм. Уг хэрэг явдал Персийн буланд олон жил үзэгдээгүй хямрал үүсгэсэн билээ.

Ноён Эмади манай сонинд ярихдаа “Бид ямар ч зүйлийг зогсоохгүй. Харин гаднах бэлэн мөнгөө дотогш оруулж байгаа. Үүнийг Сангийн яам болон агентлагуудаар дамжуулан хийж

байгаа нь өнөөгийн нөхцөлд хэвийн зүйл. Бидний авч буй арга хэмжээ бол урьдчилан сэргийлэх ач холбогдолтой” хэмээв. Moody’s зэрэглэлийн агентлаг өнгөрсөн сард Катар хямралаас хойш эдийн засагтаа 38.5 тэрбум ам.доллар оруулсныг мэдэгдсэн. Катарын хөрөнгө оруулалтын агентлаг 300 тэрбум ам.долларын өртөгтэй хөрөнгийн хямралын өртөгтэй хөрөнгийн хямралын материялыг агаад Лондонд Shard барилга, Harrods болон эдийн засгийн “жийрэг” болгон ашиглана гэж Сангийн сайд мэдэгдлээ. Саудын Араб, Эмират, Бахрейн, Египет улсууд Катартай зургадугаар сард дипломат харилцаагаа тасалж, тээврийн шугамаа хаасны дараа эндээс 30 тэрбум ам.доллар гадагш урсан юм. Уг хэрэг явдал Персийн буланд олон жил үзэгдээгүй хямрал үүсгэсэн билээ.

Тус сан сүүлийн саруудад Credit Suisse банк, Оросын нефть олборлогч Rosneft, Tiffany & Co үнэт эдлэлийн компани зэрэгт эзэмшлээ багасгасан юм. Гэвч ноён Эмади ярихдаа үүнийг хямрал бус хөрөнгө оруулалтын стратегияр тайлбарлав. Тэрбээр сан цаашид идэвхтэй ажиллахыг онцлоод “Бидэнд хангалттай хөрвөж хөрөнгө бий. Хэрэв боломж харгадвал хөдөлгөөн хийнэ. Бизнес ба стратегиа зогсоохгүй” гэсэн байна.

Катар улс шингэрүүлсэн хийн экспорттоор дэлхийд тэргүүлэгч бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр хамгийн баян орнуудын нэг. Тус улс 2022 онд Дэлхийн хөл бөмбөгийн аваргын тэмцээнийг зохион байгуулахад зориулж, долоо хоногтоо 500 сая ам.доллар зарцуулж буй. Гэвч хөршүүд нь Катарыг терроризмыг дэмжсэн хэмээн буруутгаж, хориг тавьсан учир үйл ажиллагаанд нь саад учирсан. Доха уг шүүмжлэлийг няцаасан боловч энд хүнс, барилгын материалын үнэ тэнгэрт хадаж, худалдааны шинэ түнш хайхад хүрчээ. Ноён Эмадийн хэлснээр Катарын гадаад худалдаа хямралын эхний сард 40 хувиар унасан боловч буцаад 99.9 хувийн түвшинд ирээд байгаа гэнэ.

Катарын банкны системээс хасагдсан мөнгөний ихэнхийг хориг тавьсан улсууд татан авчээ. Хөрөнгө гарах хэмжээ нэгэнт дээд түвшиндээ хүрсэн тул цаашид капитал гадагш урсахгүй гэж сайд үзэж байна. Хямрал дараах цөөн долоо

хоногт жаахан түвэгтэй байсан авч байдал хэвийн болж эхэлжээ. Ноён Эмади “Одоогийн түвшин бидэнд таатай байгаа. Гэхдээ шаардлагатай бол бид зах зээлээ хамгаална. Системийн эрдэл үүсвэл зохих арга хэмжээ авах болно. Хэрвээ ийм зүйл хийхэд хүрвэл бид өөрсдийгөө хязгаарлахгүй” хэмээв.

Тэрбээр нөхцөл байдал тааламжтай бол олон улсын капиталын зах зээлд хандах боломжтойг тэмдэглэв. Персийн булан дахь АНУ-ын холбоотон улсуудын хурц маргаан мухардалд ороод байгаа юм. Хориг тавьсан Засгийн газрууд Дохагаас нөхөн төлбөр авах болон Катарын Аль Жазира телевизийн сувгийг хаах шаардлага хүргүүлсэн нь хэтийгдсэн зүйл болжээ. Ноён Эмади ярилцлагаа “Би энэ бүхэн төгсөнө гэж найдаж байгаа. Үгүй бол бид эдийн засгаа тогтвортой авч явах төлөвлөгөө боловсруулсан. Хойг байсан бол бид ганц арал шиг боллоо” гэсэн үгээр өндөрлөв.



## АНУ 1965 онд Индонезийн аллагыг дэмжсэн нь нотлогдов

Критика Варугур

Жакарта дахь Элчин сайдын яамны ил болгосон архиваас үзэхэд 1965-1966 онуудад Индонезийн цэргийнхэн коммунист болон тэрслүү үзэлтэн гэж тооцогдсон 500 мянгаас нэг сая хүнийг хөнөөсөн хэргийг АНУ-ын албаныхан анхааралтай ажиглаж байжээ. Энэхүү аллагын цаадах учир шалтгааны талаар маргаан байдаг. Гэвч коммунизмыг талархагч гэж сэжиглэгдсэн нэг сая орчим хүнийг хөнөөсөн явдлыг АНУ-ын албаныхан идэвхтэй дэмжиж байсныг тус улсын баримт бичгүүд нотолж байгаа юм. Жакарта дахь АНУ-ын ЭСЯ-ны 30000 орчим хуудас баримтыг мягмар гарагт дэлгэсэнээс үзэхэд Америкийн албаныхан аллагыг ажиглаж, хүйтэн дайны оргил үед Индонезийн цэргийнхний мөнгө, тоног төхөөрөмжөөр хангахын хамт коммунист гэгдэх хүмүүсийн нэрсийн жагсаалт гаргаж өгсөн аж.

Баримтаас үзэхэд 1965 оны есдүгээр сард Индонезийн коммунист намын тушаалаар цэргийн эргэлт хийхийг завдсан ял тулгаж, зургаан генералыг

цаазалсан хэргийг үгүйсгэх найдвартай баримт АНУ-ын албаныханд байсан байна. Уг аллага Сухартогийн цэргийн дэглэм 32 жил үргэлжлэх замыг зассан юм. Баримтыг цахимд оруулах ажлыг эрхэлж буй Барын хойдын их сургуулийн Индонезийн түүхийн профессор Брэдли Симпсон “Энэ бол тухайн үеийн Индонезийн улс төрийн хамгийн том бөгөөд өргөн хүрээтэй баримт юм. Ялангуяа Индонезийн Засгийн газар тэр үеийн баримтуудаа ил болгоогүй байгаа” хэмээв.

1965 оны арваннэгдүгээр сарын баримтаас үзэхэд АНУ-ын албаныхан зургаан генералыг цаазлах явдал коммунист намтай холбоогүй. Харин дэглэм доторх засгийн эрхийн төлөө тэмцлээс үүдэлтэй талаар мэдээлэл авсан байжээ. Британийн Колумбын их сургуулийн Индонезийн түүх судлаач Жон Руза “Генералуудыг хөнөөсөн нь Сухартогийн дэглэм орших гол үйл явдал болсон. Тэр үед АНУ-ын Элчин сайд байсан Маршалл Грин 1965 оны хуйвалдаан гэгч нь зохиомол зүйл гэдгийг ойлгож байсан боловч цаазыг гүйцэтгэх

1965-1966 онуудад Индонезийн цэргийнхэн коммунист болон тэрслүү үзэлтэн гэж тооцогдсон 500 мянгаас нэг сая хүнийг хөнөөсөн хэргийг АНУ-ын албаныхан анхааралтай ажиглаж байжээ.



зөвшөөрөл өгснийг баримт харуулж байна” гэжээ. Эдгээр баримт Индонезийн цэргийнхэн коммунист хэмээн сэжиглэсэн хүмүүсээс авсан өчиг худал гэдгийг АНУ-ын албаныхан мэдэж байсныг гэрчиллээ. Ил болгосон архив голдуу 1964-1968 онуудад Жакарта дахь АНУ-ын ЭСЯ-ны өдөр тутмын тэмдэглэлээс бүрдэж буй. Тэр үед Индонези улс

колоницоллын дараах үндэстний эцэг гэгддэг Ерөнхийлөгч Сукарногийн ганцаар захирах дэглэмээс гарах түүхэн эгзэгтэй цаг үе таарсан юм. 1967 оны нэг хавтсанд Сухарто Индонезийн удирдлагыг гартаа авах нь тодорхой болсон үед АНУ дарангуйлагч дэглэмийн амжилтад гол үүрэг гүйцэтгэсэн гэж бичсэн байв.

Авлигын эсрэг Transparen-

cy International байгууллага Сухарто амьдралынхаа туршид Индонезиэс 30 тэрбум ам.доллар шамшигдуулсан гэж дүгнэсэн юм. Түүнчлэн АНУ бөөнөөр аллагын дараах он жилүүдэд Индонезийн байгалийн баялгийг хуваарилахад оролцож байсныг гэрчлэх баримт архив бий. Дэглэм өөрчлөгдөх үед Индонезийн эдийн засаг нурсан бөгөөд 1967 оны хоёр баримт

Сухартогийн захиргаа өрнөдийн компаниудыг Индонезид буцаан ирүүлэхийг оролдож байсныг гэрчилнэ. Архивыг ил болгох төслийг АНУ-ын Засгийн газрын харьяа Үндэсний ил болгох төв болон Жорж Вашингтоны их сургуулийн дэргэдэх Үндэсний аюулгүй байдлын архив хэмээх ашгийн бус байгууллага хоёр хамтран хэрэгжүүлж байгаа юм байна.



## Эдийн засаг

ХӨДӨӨ АЖ АХУЙ

## Мацаж буй махны экспорт

**Махны экспортын орлого хэдийнэ 60 тэрбум төгрөгийг давчихаад байна**

Г.Байгал  
@baigalZGM

Малынхаа махыг мөнгө болгох монголчуудын хүсэл биелж эхлэв. Махны экспортын орлого хэдийнэ 60 тэрбум төгрөгийг давчихаад байна. Гаалийн ерөнхий газрын мэдээллээр энэ оны эхний сард Монгол Улс 25.2 сая ам.долларын мах, махан бүтээгдэхүүн экспортолжээ. Энэ нь олон жилийн дээд үзүүлэлт төдийгүй өмнөх дүнгүүдийг хэд нугалсан өсөлт. Тухайлбал, махны экспорт харьцангуй сайн байсан өнгөрсөн оныхтой харьцуулахад өнөөгийн үзүүлэлт гурав дахин өндөр байна. Цаашлаад 2014 оныхоос бараг 10, 2015 оныхоос даруй 4-5 дахин өндөр болохыг албан мэдээллээс харж болно. Мах тойрсон өсөлт ингээд дуусахгүй. Хонь болон ямааны махны экспорт одоогоор найм дахин өсчихөөд байна.

Сүүлийн жилүүдэд тогтмол уруудсан махны экспорт ийнхүү мацаж эхлэв. 2017 он махны салбарынханд амар жил байгаагүй. Манай улсын хөдөө аж ахуйн салбарын түшиц нутаг болох Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь зэрэг аймагт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч, хил хорио тогтоосон юм. Хийсч ирсэн халдварт өвчний улмаас манай худалдан авагчид ч анхаарлын дохио асааж, махны экспортыг түр зогсоосон. Үүнээс үүдэн Монголын эдийн засгийн нэг найдвар болсон энэ төрлийн бүтээгдэхүүний экспортод бараан төсөөлөл давамгайлж эхэлсэн юм. Харин оны эхний сөн сарын дахь дүнг үзвэл махны экспорт итгэл дагуулсан үзүүлэлттэй угтаж байна. Махны худалдаа тойрсон тоо үзүүлэлтүүд үлэмж хэмжээгээр огцом өсчээ. Уг өсөлт адууны махны экспортод хамгийн тод ажиглагдсан.

Махны экспортын нийт ор-



Энэ онд адууны махны экспорт ойролцоогоор хоёр дахин өсөж, 20 сая ам.доллар давсан байна. Адуу битүү туурайтай амьтан учраас шүлхийн аюулаас харьцангуй хол.

Б.Ганбаатар / ЗГМӨ

логын 80 хувийг зөвхөн адууны мах бүрдүүлжээ. Энэ онд адууны махны экспорт ойролцоогоор хоёр дахин өсөж, 20 сая ам.доллар давсан байна. Адуу битүү туурайтай амьтан учраас шүлхийн аюулаас харьцангуй хол. Тиймээс энэ төрлийн махны экспорт эрүүл ахуйн хоригийг тойрч, гадаад зах зээлд чөлөөтэй гарчээ.

Мөн энэ онд махны шинэ зах зээлүүдийн үүдийг нээж, “Мах, сүүний анхдугаар аян” эхлүүлсэн нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаанд хөшүүрэг болсон. Тодруулбал, өнгөрсөн долдугаар сараас Монгол Улс Иран улс руу хонинны мах экспортолж эхэлсэн юм. Манай Eco food trading, Darkhan meat foods болон “Мах

маркет” компани Исламын Бүгд Найрамдах улс руу нийлүүлэлт хийж байна. Мөн зах зээлээ тэлэхээр Вьетнам улсад мах

нийлүүлэхээр зэхэж байгааг ч дурдах нь зүйтэй. Үүнээс гадна махны уламжлалт зах зээл болох ОХУ, БНХАУ, Япон, Казахстанд

экспорт хийж байна.

Гэхдээ малын гоц халдвар өвчин гарсны улмаас урд хөршийг чиглэх хонь, ямаа, үхрийн махны экспорт түр хоригт өртсөн. Одоогоор боловсруулсан болон адууны мах Хятад улсыг зорьж байна. Манай махны экспортын хамгийн том худалдан авагч өмнөд хөрш нийт орлогын дийлэнхийг бүрдүүлж байгаа юм. Тус улс адууны махнаас гадна дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүний импортоо нэмээд буй. Үүнээс үүдэн энэ аргаар боловсруулсан махны худалдаа ч тэлжээ. Өнгөрсөн оны өдийд манай улс дулааны аргаар боловсруулсан 980 тонн мах экспортолж байсан бол энэ оны есдүгээр сарын байдлаар хоёр дахин өсөж, 1800 тонныг давжээ. Дулааны аргаар боловсруулсан мах нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн учраас үнийн хувьд харьцангуй өндөр байдаг байна.

Тиймээс өдгөө тавд хүрээд буй дулааны аргаар мах боловсруулдаг үйлдвэрийн тоог нэмэх бодлого баримталж байна. Энэ сарын эхээр БНХАУ-ын эрх бүхий байгууллагын төлөөлөгчид мах худалдан авахаар манай долоон аймгийн 36 үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан. Улмаар Хятадын тал хянан магадлал хийж, хариу илэрхийлэх аж.

## Махны экспорт өнгөрсөн оныхоос гурав дахин өсөж, 25.2 сая ам.долларт хүрэв

Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газраас тусгай бүс байгуулахаар болсон. Монгол Улс газар нутгаа гурван бүсэд хуваан, мах экспортолж байгаа. Гэхдээ эдгээр бүсээ дотор нь дахин хязгаарлалт тогтоож, тусгай бүс байгуулахаар болсон. Ингэснээр малын гол халдварт өвчнөөс сэргийлж, махны экспортыг тогтвортой түвшинд барих боломжтой гэж үзэж байна.

Гэхдээ энэ салбарт өнөөг хүртэл толгойн өвчин болж буй нэг зүйл бий. Энэ нь санхүүжилт. Манайд махны чиглэлийн 50 гаруй үйлдвэр бий. Гэвч эргэлтийн хөрөнгөгүйгээс өдгөө тал нь л үйл ажиллагаа явуулж байна. Хэрэв эдгээр үйлдвэрийг санхүүгээр тэтгэн, хөл дээр нь дахин босговол махны экспортын боломж илүү ч нэмэгдэж таарна. Тиймээс махны үйлдвэрүүдийн зүгээс үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын тулд урт хугацаатай зээл авах хүсэлтэйгээ илэрхийлж байна. Салбарын яам, мэргэжлийн холбоод ч тэдний хүсэлтийг хүлээн авахын зэрэгцээ эх үэсвэрийн эрэлд гараад байгаа ажээ. [ЗГМ]

## ЗГМ ТОВЧХОН

» АМЬЖИРГАА

2

Жил. Сүүлийн хоёр жил буурсан өрхийн бодит орлого хоёр улирал дараалан өссөнөөр хэрэглээний өсөлтийг дэмжив.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Монголын хөрөнгийн зах зээлийн MSE ALL индекс пүрэв гарагийн байдлаар 0.18 хувиар буурч, 1167.92 нэгжид хүрлээ.

» АЖ ҮЙЛДВЭР

2.2

Их наяд төгрөг. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний найман сард 8.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.2 их наяд төгрөгөөр өслөө.

» ЭРЧИМ ХҮЧ

Дэлхийн хамгийн анхны хөвөгч салхин парк Hywind Шотландын хойд хэсэгт цахилгаан эрчим хүч нийлүүлж эхэллээ.

» ХӨРШ

6.8

Хувь. БНХАУ-ын эдийн засаг өнгөрсөн улиралд жилийн дүнгээр 6.8 хувиар өслөө.

» ХУДАЛДАА

8.6

Хувь. Онлайн болон дуудлага худалдааны үйлчилгээний eBaу компанийн орлого гуравдугаар улиралд 8.6 хувиар өсөж, 2.41 тэрбум ам.долларт хүрлээ.

12

Хувь. Япон улсын экспорт есдүгээр сард 10 дахь сардаа дараалан өслөө. Тус улсын экспорт жилийн дүнгээр 14.1, импорт нь 12 хувиар дээшилжээ.

» ДЭЛХИЙД

5.5

Хувь. Австралид өнгөрсөн сард 19.8 мянган иргэн шинээр ажлын байртай болжээ. Тус улсын ажилгүйдлийн түвшин 5.5 хувьд хүрчээ.

1.25

БНСУ-ын төв банк мөнгөний бодлогын жишиг хүүгээ хадгалж, 1.25 хувьд хэвээр үлдээв.

## ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2,455.84
Евро	2,901.21
Япон иен	21.80
ОХУ рубль	42.72
БНХАУ юань	370.92
БНСУ вон	2.17

ҮЙЛДВЭРЛЭЛ

## Ноолуурын компаниудын орлого дунджаар 28 хувиар өсчээ

Ж.Жаргалмаа  
Шинжээч

Монгол Улс ноолуурын дотоодын эрэлтээ 100 хувь хангаж байна. Оны эхний сөн сарын байдлаар самнасан ноолуурын экспортын хэмжээ 672 тонн буюу 23.7 сая ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35 хувиар өссөн дүн боллоо. Мөн сүүлийн нэг жилийн хугацаанд Европын орнуудаас тэмээний ноосон хөнжлийн

захиалга нэмэгдсэн талаар Ноос, ноолуурын холбоо мэдээллээ. Оны эхний сөн сард гэхэд нийт 25 мянган ширхэг тэмээний ноосон хөнжил экспортод гаргасан байна. Энэ дүн жилийн өмнөхөөс 3.2 дахин өссөн үзүүлэлт юм.

Харин боловсруулаагүй ноолуурыг голчлон Европын зах зээлд гаргаж байна. Ялангуяа Италид хамгийн их буюу 90 орчим хувийг экспортолжээ. Мөн зургаан хувийг Англи, 2.5 хувийг Энэтхэг, 0.25 хувийг Японд гаргаад байна.

УУЛ УУРХАЙ

## Далд уурхайн IV босоо амны ажлыг 2018 оноос эхлүүлнэ


Э.Эрдэнэтуяа  
Шинжээч

Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Entrée Resources компани “Оюутолгой”-н далд уурхайн IV босоо амын ажлыг 2018 оноос эхлэхээ мэдэгдлээ. Энэ нь “Оюутолгой” компанигай хамтарсан төсөл дэх анхны томоохон бүтээн байгуулалт болж байгаа юм. Хойд Хюго орд нь “Оюутолгой” төслийн хамгийн өндөр алт, зэсийн агууламжтай хэсэгт тооцогддог. IV босоо ам баригдах нь энэ хэсгийн олборлолтод дэмжлэг

болно гэж тус компани мэдэгдэлдээ дурджээ. Мөн бүтээн байгуулалтын ажлыг 2021 онд дуусгахаар төлөвлөсөн онд дуусгахад төлөвлөсөн Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Mongolian Mining Corporation өнгөрсөн улирлын үйл ажиллагааны тайлангаа танилцуулсан байна. Тус компани нүүрсний олборлолтоо 2016 оны мөн үеэс 284 хувиар нэмэгдүүлж, нийт 2.1 сая тонн нүүрс олборложээ. Түүнчлэн нүүрсний борлуулалт нь өнгөрсөн улиралд жилийн өмнөхөөс 251 хувиар өсөж, 891 мянган тонн болсон байна.


## Махны экспортын орлого

Эхний сөн сард  
(сая ам.доллараар)



## Адууны махны экспортын орлого

(сая ам.доллараар)



## ХААН БАНК

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2017.10.17

ХААН БАНКНЫ ОРОН НУТГИЙН ТООЦООНЫ ТӨВҮҮДИЙН БАРИЛГА  
УГСРАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ХААН Банкны орон нутгийн тооцооны төвүүдийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтанд эрх бүхий компаниудыг оролцохыг урьж байна.

Д/д	Сонгон шалгаруулалтын нэр	С/Ш дугаар	Барилгын хэмжээ
1	Баянхонгор салбарын Галуут тооцооны төвийн барилга угсралтын ажил	17/2017	9x12 хэмжээтэй, цутгамал төмөр бетон каркасан барилга, цэвдэг хөрстэй, /1 давхар/
2	Увс салбарын Өндөрхангай тооцооны төвийн барилга угсралтын ажил	18/2017	9x12 хэмжээтэй, цутгамал төмөр бетон каркасан барилга, цэвдэг хөрстэй, /1 давхар/

Оролцох хүсэлтэй барилга угсралтын компаниуд ХААН Банкны 50000045450000009 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтыг албан бичгийн хамт ирүүлэн сонгон шалгаруулалтын өгөгдлийг авах боломжтой.

Материалыг 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 16:00 цаг хүртэл ХААН цамхаг оффисын ресепшин хүлээн авч зөвхөн шалгарсан компанид бичгээр хариу мэдэгдэнэ.

Оролцогчдын бүрдүүлж өгсөн материалыг буцаан олгохгүй болохыг анхаарна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, Стадион Оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, ХААН Банк цамхаг

Жич: Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг real\_estate@khanbank.com хаягт хандгаж авна уу.

Харилцагчийн мэдээллийн төв 1800-1917

www.khanbank.com

khanbank.com/facebook

khanbank.com/twitter

## Эдийн засаг

### БАРИЛГА

# Орон сууцны үнэ метр квадрат нь 1.2-1.4 сая төгрөг байх боломжтой

**Иргэд орон сууцны хөөсөрсөн үнэ буухыг хүлээж байна**

Б.Сэлэнгэ  
ЗГМ

Орон сууцны зах зээлийн өнөөгийн байдлын талаар Монголын барилгачдын холбооны Ерөнхийлөгч М. Батбаатартай ярилцлаа.

-Энэ өдрүүдэд УИХ-аар шинэ сайдуудыг томилж байна. Шинэ Засгийн газар барилгын салбарт ямар бодлого баримтлах бол. Та ямар хүлээлттэй байгаа вэ?

-Жил гаруйн хугацаанд Монголын барилгын салбарын бүтээн байгуулалт зогсонги байдалд ороод байна. Тэр дундаа ард түмний дунд хамгийн хэргэцэтэй байсан найман хувийн ипотекийн зээл олголт зогсонги байдалд орсноос болоод энэ салбарт нэлээн асуудал хуримтлагдчихлаа. Эдгээр асуудлыг өөр өнцгөөс харж, эрчтэй, хурдтай шинэчлэлийг барилгын салбарт хийх байх аа гэсэн итгэлээр шинэ Засгийн газрыг харж байна.

-Барилгын салбарын хөгжил идэвх ипотекийн зээлтэй шууд холбогдож байгаа. Энэ зээлийг цаашид хэвийн олгох боломж байгаа болов уу?

-Энэ Засгийн газрыг анх байгуулахаас эхлээд Монголын барилгачдын холбооны зүгээс орон сууцны ипотекийн зээлийг яг голдрилоор нь хөгжүүлж гэж хэлж байсан. Арваад жилийн өмнө үнэт цаасны хоёр дахь зах

зээл буюу орон сууцаар барьцаалсан үнэт цаасны зах зээлийн механизмыг оруулж ирвэ гэсэн. Тэр нь орон сууцны Засгийн газрын бонд. Улмаар ипотекийн зээлийн тусдаа эх үүсвэртэй болох асуудал байгаа. Энэ саналыг олон удаа тавьсан. Монголын барилгачдын холбооны зүгээс санал боловсруулаад Төрийн орон сууцны корпораци, Монголын банкуудын холбоо, Худалдаа хөгжлийн банкинд санал дэвшүүлээд гурван сар болж байна. Сая Монгол Улсын Ерөнхийлөгч шинэ сайд нартай уулзаж байхад Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд "орон сууцны Засгийн газрын бонд гаргахад анхаар" гэсэн чиглэл өгсөн. Ерөнхийлөгчийн хэлсэн орон сууцны бонд гэдэг нь бидний яриад буй үнэт цаасны хоёр дахь зах зээл гэсэн үг.

-Зөх зээлд орон сууцны эрэлт сулраад байхад үнэ буурахгүй байна. Яагаад тэр юм бол?

-Орон сууцны зах зээлд судалгаа хийдэг хэдэн том байгууллага манайд бий. Гэхдээ эдгээр байгууллагаас зах зээлд буй орон сууцнаас хэд нь зарагдаж, үнэ яаж буурч өсөж байна гэдэг өнгөц судалгаа хийдэг. Гэтэл бодит мэдээллийг Засгийн газарт өгч чадахгүй байна. Орон сууцны хямд өртгөөр бариад өндөр үнээр зардаг байдал үе өнгөрөөсөн. Мөн цаад талд нь худалдан авагчид дандаа жирийн иргэн, албан хаагчид. Харин тэдэнд өөрсдийнх нь худалдаж авах чадварт нь таарсан дундаж үнэтэй орон сууц хэрэгтэй байна. Түүнийг нь Засгийн газарт ойлгуулж чадахгүй байгаа юм. Тиймээс шинэ Засгийн газар зах зээлийг бодитоор харах хэрэгтэй. Одоо зах зээлд бэлэн байгаа 30 гаруй мянган орон сууц яагаад зарагдахгүй хоёр жил болчихов?



ЗГМӨ

Зөвхөн хөөсөрсөн үнийг нь буухыг хүлээгээд байгаа юм. Тиймээс үүнийг гаргаж ирэх судалгааны баг хэрэгтэй байна.

### Орон сууцаар барьцаалсан үнэт цаасны зах зээлийн механизмыг оруулж ирвэ

-Таны харж байгаагаар өнөөгийн байдлаар орон сууцны үнэ буурах боломжтой гэсэн үг үү?

-Бүрэн боломжтой. Метр квадрат нь 1.2-1.4 сая төгрөг болж байж миний дээр хэлсэн зорилтот бүлгүүд орон сууцаар хангагдах боломжтой. Үүний цаана Засгийн газрын маш том бодлого явах ёстой. Тэгж байж агаарын бохирдол, гэр хорооллын

тэлэлт зэрэг асуудлуудыг шийднэ. Тиймээс нэмүү ашгийн төлөө бус жирийн ард түмнээ орон сууцаар хангах зорилго руу Засгийн газар анхаарах хэрэгтэй.

-Таны хэлсэнчлэн барилгын компаниудыг бонд, ипотекийн зээл гэх мэт олон талаар дэмжих боломжтой. Өөр ямар дэмжлэг хэрэгтэй байна. Эсвэл барилгын компаниуд төрийн дэмжлэг хүлээхгүйгээр өөрсдөө үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж байна уу?

-Одоо бол тун хэцүү болсон. Яагаад гэвэл зах зээл нь зогсонги байдалд байсаар байгаад барилгын компаниуд богино хугацаа, өндөр хүүтэй зээлийн өрийн сүлжээнд орчихлоо. Тиймээс өрийн сүлжээ нээс гаргах ажлыг салбарын яамнаас бодлогоор дэмжих ёстой. Арилжааны банкууд нэг удаа зээлийн төлөлтийг нь хойшуулж, хугацааг нь сунган, хүүг нь багасгадаг ч юм уу. Өөрөөр хэлбэл барилгын компаниудыг амсхийх боломж өгөх хэрэгтэй. Тэгж

байж бүтээн байгуулах салбар нь өндийж, бусад нь дагаад босно. Тиймээс шинэ өнцгөөс, бодит байдлаар хандах байх аа.

-Барилгын компаниуд зөвхөн ипотекийн зээл гэлтгүйгээр бүтээгдэхүүнээ борлуулах олон аргыг хэрэглэж байна. Тухайлбал банкаар дамжуулахгүй хувь зээл гаргаж байна. Энэ талаар та ямар бодолтой байдаг вэ?

-Энэ бол аргаа барсан ажил даа. Орон сууцан дээр төрийн бодлогын дэмжлэгийгээр урт хугацааны зээлийг иргэдэд өгөх бололцоо байхгүй. Тиймээс зорилтот бүлгүүдэд барилгаа зарж буй компаниудыг дэмжих хэрэгтэй. Орон сууцны үнэт цаас гаргах замаар зорилтот бүлэгт зориулан орон сууц барьж буй компанийг дэмжих хэрэгтэй байна. Тухайлбал гэр хорооллыг А, Б, В гэсэн бүс болгоод тэнд орон сууц барьсан компанийг дэмжин, үнэт цаасны бонд чиглүүлж болно. Ингэж чиглэсэн бодлого явуулж байж хямралаас гаргана.

-Барилгын компаниуд төлөвлөсөн газар дээрээ илүү олон айлын орон сууц барих, зай талбайн хүргэмжтэй байдлыг худалдан авагчдад олгохгүй хохироох гэх мэт оло асуудал байдаг. Энэ байдал дээр мэргэжлийн холбооны зүгээс ямар дүгнэлт хийдэг вэ?

-Орон сууц барьж байгаа компани бүрийг барилгын компаниар төлөөлүүлж болохгүй. Хөрөнгө оруулалт хийн, зураг төслөө гургуулихаад тэндээ туслан гүйцэтгэгчээр бариулж байгаа нь маш олон. Тэдгээр хөрөнгө оруулагчид зөвхөн ашгийн төлөө олон барилга бариулах гэх мэт асуудал үүсээд байна. Гэхдээ одоо бол зорилтот бүлэгт зориулсан, гэр хорооллын дахин төлөвлөлт хийсэн төлөвлөлт рүү орно.


-Барилгын түүхий эд талаасаа манайх дотоодоосоо хэр хангаж чадаж байна. Цементийн тухайд үндэсний хэд хэдэн компаниуд ашиглалтад орсон байгаа шүү дээ?

-Дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр нэлээн бодлого явуулсан. Өндөр хүүтэй зээл аваад үйлдвэр барьчихсан компаниудын бүтээгдэхүүн бас өндөр дүнтэй гарч ирээд байна. Үүнд төр бодлого явуулж, бүтээгдэхүүнийг хямдруулах боломж олгох хэрэгтэй. Тэгж байж тал талаасаа нэг цэгт очно.

-Тэгэхээр дотоодын материал үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн үнэтэй байна гэж та бодож байна уу?

-Үнэтэй байна. Тиймээс Эрэн нээс хямд материал оруулж ирж байна. Гаднаас хямдхан ч чанаргүй бүтээгдэхүүн оруулж ирж байгаа байдлыг л төр бодлогоор өөрчлөх ёстой юм. [ЗГМ]

## Алтны ханш өсөв



Олон улсын зах зээлд дөрвөн хоног дараалан сулраад байсан алтны ханш өслөө. Энэ сарын 13-нд 1300 ам.долларыг давж байсан тус металлын ханш үүнээс хойш тасралтгүй буурсан. Харин пүрэв гарагт эргэн сэргэж, 0.1 хувиар өссөнөөр, 1282.80 ам.долларт хүрчээ. Үүнтэй зэрэгцээд ам.долларын ханш харьцангуй тогтвортой байгаа. Голлох зургаан

валюттай харьцуулан тооцдог ам.долларын спот индекс гэхэд 93.340 нэгжид хүрсэн. Иентэй харьцах ам.долларын ханш харьцангуй тогтвортой байсан. Харин Brent төрлийн газрын тосны ханш 0.1 хувиар доошилж, баррель нь 58.11 ам.долларт хүрчээ. Гэхдээ тус түүхий эдийн ханш гурван долоо хоногийн дээд цэг хэвээр байна. [ЗГМ]

МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР АМЖИЛТЫН ҮНДЭС

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC  
УТАС: +976 76009293  
support@ism.mn

### МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	69.12	▼ -2.54%	10/19/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▼ -13.64%	10/19/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	7.25	▲ +7.41%	10/19/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.018	▼ -10%	10/19/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	10/19/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	4.7	▼ -6%	10/19/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.1	▼ -2.38%	10/19/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.255	▼ -5.56%	10/19/2017
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.54	▼ -1.85%	10/19/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.285	▼ -8.06%	10/19/2017

### ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1282.80	▲ +0.18%	10/19/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	922.7	▼ -0.21%	10/19/2017
МӨНГӨ	SIA	унци	16.99	▼ -0.04%	10/19/2017
ЗЭС (COMEX)	HGA	фунт	6990	▼ -0.53%	10/19/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	61.1	▲ +0.34%	10/19/2017
WPI TOS	CLA	баррель	51.91	▼ -0.25%	10/19/2017
БРЕНТ	COA	баррель	58.01	▼ -0.24%	10/19/2017
БЕНЗИН	XBA		165.71	▲ +0.86%	10/19/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	2.877	▲ +0.81%	10/19/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	10/19/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	95.1	▲ +1.22%	10/19/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.140	▲ +0.36%	10/19/2017
БУДАА	RRA	центнер	11.885	▼ -0.5%	10/19/2017
БУУДАЙ	WA	бушель	429.75	▼ -0.06%	10/19/2017
КАКАО	CCA	тонн	2067	▲ +0.15%	10/19/2017
КОФЕ	KCA	фунт	1.243	▲ +0.12%	10/19/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
<b>ЭНЭ ӨДӨР I АНГИЛАЛД</b>				
АПУ ХК	APU	747.43	▲ 0.8%	10/19/2017
ГОВЬ ХК	GOV	20980	▲ 2.44%	10/19/2017
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	527.61	▼ -1.91%	10/19/2017
СҮҮ ХК	SUU	235.18	▼ -2.71%	10/19/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	26100	▲ 2.43%	10/19/2017
ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	9715	▼ -1.22%	10/19/2017
<b>ЭНЭ ӨДӨР II АНГИЛАЛД</b>				
БИ ДИ СЕК ХК	BDS	1333	▼ -2.7%	10/19/2017
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК	BNG	35280	▼ -2%	10/19/2017
АРИГ ГАЛ ХК	EER	4000	◀▶ 0%	10/19/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	74.97	▲ 1.37%	10/19/2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HBM	152	▲ 4.97%	10/19/2017
ЖЕНКО ТҮР БЮРА ХК	JTB	62.94	▼ -3.17%	10/19/2017
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MCH	555.97	▲ 2.87%	10/19/2017
МОНИНЖАР ХК	MIB	148	◀▶ 0%	10/19/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

### ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6624.219	+0.56	▲ +0.01%	10/19/2017
DAX INDEX	DAX	13032.86	-10.17	▼ -0.08%	10/19/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15782.16	-34.74	▼ -0.22%	10/19/2017
S&P/ASX 200	AS51	5896.129	+5.65	▲ +0.1%	10/19/2017
S&P 500	INX	2561.26	+1.9	▲ +0.07%	10/19/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3370.172	-11.62	▼ -0.34%	10/19/2017
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	23157.6	+160.16	▲ +0.7%	10/19/2017
TOP 20	MSETOP	20938	+28.83	▲ +0.14%	10/19/2017
FTSE 100	UKX	7521.21	-21.66	▼ -0.29%	10/19/2017
HANG SENG	HSI	28222.65	-489.11	▲ -1.7%	10/19/2017
NIKKEI 225	NKY	21448.52	+85.47	▲ +0.4%	10/19/2017